

## ТӨВ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН 2019 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2019 оны 06 дугаар  
сарын 27-ны өдөр

Төв аймаг  
Зуунмод сум

### Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар:

-Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын болон захиргааны үйл ажиллагааны баримт бичгийн зүйл, заалтын хэрэгжилтийг хэрхэн зохион байгуулж, хангаж буй талаар:

Тус газар нь Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их хурал, Засгийн газрын хөтөлбөр, зарлиг, тогтоол, шийдвэрүүдийг хэрэгжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, шинэчлэн батлагдсан хууль тогтоомж болон бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэгтэй уялдуулан байгууллага, алба хаагчдын ажил үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд иргэд олон нийтэд ил тод хүртээмжтэй хүргэхэд тодорхой зорилт дэвшүүлэн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Цагдаа, дотоодын цэргийн командлагчийн “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2019 онд хэрэгжилтийг хангах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, биелэлт үр дүнг тооцох баримт бичгийн жагсаалт батлах тухай” 2019 оны А/42 дугаар тушаал, Захиргааны удирдлагын газрын даргын 5/46 тоот зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр салбар төлөвлөгөө гарган, хариуцсан хэлтэс, тасаг, алба хаагчдад хуваарилан, хөтөлбөр, төлөвлөгөө, тогтоолын биелэлтэнд Засгийн газрын 89 дүгээр тогтоолын дагуу хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж холбогдох алба, хэлтэст тогтоосон хугацаанд бүрэн тайлагнасан.

2019 оны эхний хагас жилд тус цагдаагийн газарт Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн актууд, үүрэг, даалгавар, хөтөлбөр, шийдвэр 135 ирүүлснийг холбогдох хэлтэс, тасаг, хэсгүүд, хариуцах алба хаагч нарт хуваарилан хэрэгжилт, үр дүнг тооцон ажиллаж байна. Шинээр батлагдсан, нэмэлт өөрчлөлт орсон хууль тогтоомж, эрх зүйн акт, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмуудыг албаны сургалтын цагаар бие бүрэлдэхүүнд танилцуулж, танилцуулсан талаар тэмдэглэл хөтөлж байна.

Цагдаагийн ерөнхий газраас 2018 онд хяналтад авч, хэрэгжилтийг зохион байгуулсан бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж өгсөн зөвлөмжийг бие бүрэлдэхүүнд танилцуулж, зөвлөмжийн хүрээнд хийх ажлын төлөвлөгөө гарган 2018 онд хэрэгжээгүй шийдвэр, биелэлт хангалтгүй тайлагнасан 2 заалтын хэрэгжилтийг нөхөн хангаж, Галт зэвсгийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хариуцан зохион байгуулж буй алба нэгжтэй хамтран ажиллах, ажлын уялдаа холбоог сайжруулах чиглэлээр хэлтэс, тасгийн дарга нарт үүрэг, ажлын чиглэл өгч, хэрэгжилт үр дүнг тооцон ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд Монгол Улсын Их хурлын 2016 оны 19 дугаар тогтоол “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”, Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоол “Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх

үндсэн чиглэл, Улсын Их хурлын Хууль зүйн Байнгын хорооны 2013 оны 02 дугаар тогтоол, 2015 оны 28 дугаар тогтоол, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2017 оны 19/15, 2018 оны 06, 05, 12/09 дүгээр зөвлөмж, Засгийн газрын 2009 оны 303 дугаар тогтоол “Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний хоёр дахь хөтөлбөр”, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратеги”, “Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс урьдчилан сэргийлэх хянах үндэсний 2 дахь хөтөлбөр”, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”, “Бүх нийтийн эрх зүйг боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”, “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний салбар төлөвлөгөө зэрэг хөтөлбөр төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Монгол улсад хууль сахиулах байгууллагын шинэчлэлтэй холбогдуулан Нээлттэй нийгэм форумас явуулж байгаа төслийн хүрээнд Төв аймгийн ажил олгогч эздийн холбоо, Өмгөөлөгчдийн холбоо, Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн холбоо, Үйлдвэрчний эвлэлийн холбоодоос тус газрын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдал, иргэд, олон нийтэд тайлан тавьж байгаа байдал зэрэгт бэсрэг мониторинг хийж үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдал хуулийн дагуу, ил тод байдал хангалттай байна гэсэн дүгнэлт гарган ирүүлсэн байна.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд хэрэгжиж буй “Байгууллагын соёлыг төлөвшүүлэх хөтөлбөр”, “Цагдаагийн алба хаагчийн харилцааны соёлыг дээшлүүлэх дэд хөтөлбөр”, “Эрүүл цагдаа хөтөлбөр”, “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын ахмад, дунд, залуу үеийн залгамж холбоог хөгжүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг 7-оос 11 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, хөтөлбөрийн хэрэгжих хугацаа, ач холбогдол, үр дүнгийн талаар иргэд, олон нийт, алба хаагчдад мэдээлэл хийж сурталчлан, хэрэгжилтийг хангах чиглэлээр удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласнаар 2019 оны эхний хагас жилийн байдлаар хөтөлбөрийн хэрэгжилт 98-аас 100 хувьтай дүгнэгдээд байна.

[-Байгууллагын даргын зөвлөлийн хуралдаан тайлангийн хугацаанд хуралдсан байдал, шийдвэрлэсэн асуудлын талаар:](#)

Цагдаагийн газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгүүлж 16 удаа хуралдаж, 123 асуудал хэлэлцсэнийг дотор нь ангилж үзвэл: удирдлага зохион байгуулалтын асуудлаар 39, хүний нөөц шагналын талаар 66, дотоод хяналт шалгалтын талаар 18 асуудал хэлэлцэж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан.

Цагдаагийн газрын даргын “А” тушаал 48 гарснаас ажлын хэсэг байгуулах тухай 18, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай 1, түр орлон гүйцэтгэгч томилох тухай салбар зөвлөл байгуулах тухай 3, комисс томилох тухай 12, сум тавьж олгох зарцуулах тухай 5, зардал гаргах тухай 1, аян зохион багуулах тухай 1, сумдыг бүсчлэн хувааж алба хаагчдад хариуцуулан ажиллуулах тухай 1, нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах тухай 1, бусад 5 тушаал гарч, биелэлт, үр дүнд хяналт тавин ажиллаж байна

Цагдаагийн газрын даргын “Б” тушаал 135 гаргаснаас ажилд томилох 11, сахилгын шийтгэл оногдуулах 10, шилжүүлэн томилох 25, ажлаас чөлөөлж, сургалтад хамруулах тухай 5, үйлдвэрлэлийн дадлага, сургалт зохион байгуулах 5, цалингийн нэмэгдэл тооцож олгох тухай 19, ажлаас чөлөөлж, шилжүүлэх тухай 6, цалин нэмж, хасах тухай 8, сургагч алба хаагч томилох тухай 9, шагнах тухай 23, чөлөө олгох тухай 7, ээлжийн амралт олгох тухай 4, цол олгох тухай 3 байна.

Цагдаагийн газар нь олон нийт цагдаагийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, цагдаагийн газрын үйл ажиллагааг ил тод нээлттэй болгож, өргөдөл гомдлыг хүлээн авах, барагдуулах ажлыг боловсронгуй болгоход орчин үеийн мэдээллийн технологийг ашиглан иргэдэд мэдээ, мэдээллийг шуурхай хүргэхэд анхаарч Цагдаагийн ерөнхий газрын [www.police.gov.mn](http://www.police.gov.mn), [www.tuv.police.gov.mn](http://www.tuv.police.gov.mn) цахим хуудас болон фейсбүүк хуудсанд мэдээ, мэдээлэл байршуулж, мэдээллийг сар тутам шинэчлэн баяжуулан ажиллаж байна.

**-Хүний нөөцийн бодлогын талаар:**

Тус Цагдаагийн газар нь холбогдох хууль тогтоомжийн хүрээнд Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийг ханган хүний нөөцийн төлөвлөлт, бодлогыг хэрэгжүүлэх, алба хаагчийг судлах, томилох, чөлөөлөх, цол олгох, шагнаж урамшуулах, сахилгын шийтгэл ногдуулах, тэтгэвэр тэтгэмж олгох, алба хаагчдын хувийн хэргийн баяжилт бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалтыг хангах, хүний нөөцийн цахим санд алба хаагчдын мэдээллийг оруулах зэргээр хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлж хууль, журам, зааврыг мөрдөн ажиллаж байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/135 дугаар тушаалаар офицер 114, ахлагч 91, энгийн 3, бүгд 208 орон тоотой батлагдсан. Одоогийн байдлаар офицер 1, цагдаа 8, энгийн 1 алба хаагчийн орон тоо дутуу. Алба хаагчдын хөдөлгөөний талаарх нэгдсэн бүртгэлийг тухай бүр, бүрэлдэхүүний хөдөлгөөний тайланг улирлаар үнэн зөв гаргаж, тогтоосон хугацаанд нь Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөц, сургалтын хэлтэст хүргүүлсэн. **Орон тооны нөхөн хангалт 95 хувьтай** байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар шинээр томилогдсон 9, хугацааны цол авсан 14, дэвшин томилогдсон 1, бусад газар хэлтсээс шилжин ирсэн 1, шилжсэн 8, албан тушаал өөрчилсөн 6, 5 жилийн мөнгөн урамшил авсан 10, нөөцөд бүртгэгдсэн 25, Цагдаагийн ерөнхий газрын дэд даргын тушаалаар 14, Цагдаагийн газрын даргын тушаалаар 1 алба хаагч ахлагч бүрэлдэхүүнд шинээр томилогдож, хугацааны цол 5, бусад газар хэлтэст шилжин ирсэн 2, шилжсэн 4, хугацааны цол авсан 5, албанаас чөлөөлсөн 2, халсан 1, албан тушаал өөрчилсөн 25, офицер бүрэлдэхүүнд орсон 2 алба хаагчийн мэдээллийг тухай бүр хүний нөөцийн санд оруулсан.

Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлөөс Хууль сахиулахын их сургуультай хамтран хугацаат цэргийн алба хаасан, бүрэн дунд боловсролтой иргэдийн дунд эргүүл, харуул, жижүүр болон эргүүлийн цагдаа, жолооч, Дотоодын цэргийн харуулчин, эргүүлчин албан тушаал /ажлын байр/-ын сул орон тоог нөхөх, нөөц бүрдүүлэх сонгон шалгаруулалт зарласантай холбогдуулан мэргэшлийн шалгалтын зарыг аймгийн “Төв”, “TBS” телевиз, Цагдаагийн газрын [Tuv.police.gov.mn](http://Tuv.police.gov.mn) цахим хуудас, Төв цагдаагийн газар фэйсбүүк хуудсанд байршуулж, 24 иргэнийг судлан материалыг Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөцийн хэлтэст хүргүүлсэн.

**Алба хаагчдын дунд зохион байгуулсан албаны сургалт, түүний үр дүнгийн талаар:**

Тус Цагдаагийн газраас Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны А/28 дугаар тушаалаар баталсан “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын мэдлэг, үр

чадварыг дээшлүүлэх 2019 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөө”, “Цагдаагийн газрын 2019 оны албаны сургалтын төлөвлөгөө”-ний дагуу алба хаагчдад албаны сургалтыг зохион явуулсан. Албаны сургалт, соён гэгээрүүлэх чиглэлээр 2018 онд зохион явуулсан ажлын мэдээллийг Цагдаагийн газрын даргын зөвлөлийн 01 дүгээр хурлаар хэлэлцүүлж, 2019 оны албаны сургалтын төлөвлөгөөг баталж хуваарь, төлөвлөгөөний дагуу албаны сургалтыг зохион явууллаа.

Цагдаагийн ерөнхий газрын дэд даргын 2019 оны 3/90 тоот зөвлөмж, ажлын чиглэл, 3/187 тоот ажлын чиглэлийг хэрэгжүүлж, 2019 оны эхний хагас жилд зохион байгуулсан албаны сургалтын мэдээллийг “Сургалтын мэдээллийн нэгдсэн бүртгэлийн сан /E surgalt /”-д шивж баяжилт хийсэн.

Алба хаагчдын санаачилгаар Цагдаагийн газрын сургалтын зааланд засвар хийн, шинээр 75 ширхэг сандал, 20 ширхэг ширээ, 1 ширхэг зурагт байрлуулж, сургалт явагдах орчин нөхцөлийг сайжруулж, тохилог, цэвэр үзэмжтэй болгосон

Тус газрын алба хаагчид, тэдний гэр бүлийн хүмүүсийг хөгжүүлэх чиглэлээр “Хөгжлийн өргөө”-г шинээр барьж байгуулан, алба хаагчдын хүүхдүүдэд дугуйлан хичээллүүлэх, алба хаагчдад “Англи хэл-30 хором” аяны хүрээнд гадаад хэлний сургалт явуулахад ашиглаж байна. Уг “Хөгжлийн өргөө”-д шинээр тавцантай сандал 25 ширхэг, самбар 1 ширхэг, ус буцалгагч 1 ширхгийг тус тус байрлуулсан.

Цагдаагийн газрын 2019 оны албаны сургалтын төлөвлөгөөний дагуу эхний хагас жилд 53 удаагийн сургалт зохион байгуулж үүнээс мэдвэл зохих хууль тогтоомжийн сургалт 10, алба хаагчийг хөгжүүлэх сургалт 6, дадлагажуулах сургалт 3, бие бялдрын бэлтгэлжилтийн сургалт 22 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 8872 алба хаагч хамрагдсан байна.

Цагдаагийн ерөнхий газрын сургалтын нэгдсэн төвөөс зохион байгуулсан мэргэшүүлэх болон давтан сургалтад давхардсан тоогоор 65 алба хаагч хамрагдсан.

Хууль сахиулах их сургуулийн 2018-2019 оны хичээлийн жилийн “Цагдаа-хууль сахиулах ажил” мэргэжлийн бакалаврын сургалтад 2 алба хаагч, мөн Хууль сахиулахын Их сургуулийн Удирдлагын академийн 2019-2020 оны хичээлийн жилийн “Цагдаагийн стратеги-тактик, удирдлага” магистрын сургалтад 1 алба хаагч суралцсан.

Цагдаагийн ерөнхий газрын Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэс, Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба, Мөрдөн байцаах алба, Тээврийн цагдаагийн албанаас цагдаагийн төрөл, мэргэжлийн чиглэлээр зохион явуулсан 10 удаагийн цахим сургалтад давхардсан тоогоор 81 алба хаагч хамрагдсан байна.

Сумдын хэсгийн төлөөлөгч нарын сургалт, цугларалтыг 2 удаа, ахлагч бүрэлдэхүүний сургалт, цугларалтыг 1 удаа зохион байгуулж Эрүүгийн цагдаагийн алба, Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба, аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын газрын сургагч багш, холбогдох албаны хүмүүсийг урьж “Хэргийн газрын ул мөр бэхжүүлэх ажиллагаа”, “Хэрэг бүртгэлтийн хэрэг, зөрчил шалгаж шийдвэрлэхэд анхаарах асуудал”, “Хүний эрхийг хангах”, “Гэр бүлийн харилцаа ба үнэт зүйлс”, “Хүүхдийн хөгжлийг дэмжихэд эцэг, эхийн үүрэг оролцоо” сэдвээр сургалт зохион байгуулсан.

Алба хаагчдын дунд “Сахилга хариуцлагыг дээшлүүлье”, “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын сахилга, ёс зүй, аюулгүй байдлыг сайжруулах, авлигын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх” сэдэвт илтгэлийн уралдааныг 2 удаа зохион байгуулж, 21 алба хаагчийн илтгэлийг хэлэлцүүлж эхний 3-н байранд шалгарсан 6 алба хаагчийн сарын үндсэн цалинг 10-20 хувь нэмэгдүүлэхээр шийдвэрлэж батламж хадгалуулсан. Шалгарсан илтгэлийг “Сахилга хариуцлагын зөвлөгөөн”-ий үеэр нийт бие бүрэлдэхүүнд танилцуулж сурталчилсан.

Цагдаагийн газрын даргын 2019 оны А/11 тоот тушаалаар “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын ахмад, дунд, залуу үеийн залгамж холбоог хөгжүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг Захиргааны удирдлагын тасгийн даргаар ахлуулан 12 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх салбар төлөвлөгөөг гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн газрын даргын энэ оны А/31, 32 тоот тушаалаар “Үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх баг”, “Зөвлөн зааварлах баг”-ийг байгуулж, Цагдаагийн ерөнхий газрын дарга асан, хошууч генерал Д.Пүрэв, Боловсон хүчний асуудал эрхэлсэн дэд даргаар ажиллаж байсан цагдаагийн бэлтгэл дэд хурандаа С.Дашдорж, цагдаагийн бэлтгэл ахмад Л.Хуягбаатар, Зууны манлай замын байцаагч, цагдаагийн бэлтгэл дэд хурандаа А.Чумхаан нарыг урьж нийт бие бүрэлдэхүүнтэй “Уламжлал ба шинэчлэл” уулзалт ярилцлагыг 3 удаа зохион байгуулсан. Хөтөлбөрийн хүрээнд ахмадуудтай хийсэн уулзалт, ярилцлага, мэдээлэл, тэдний сургамж үг, хэрэгжүүлж байгаа ажил, арга хэмжээний талаар сургалтын видео шторк бэлтгэн Цагдаагийн газрын фейсбүүк хуудсанд байршуулсан. Ахлах мөрдөн байцаагчаар ажиллаж байгаад цэргийн байнгын тэтгэвэрт гарсан цагдаагийн бэлтгэл хошууч Ц.Бурмаа Мөрдөн байцаах тасгийн мөрдөгч нарын шалгаж байгаа ээдрээ түвэгтэй, олон удаагийн үйлдэлтэй 10 хэрэгтэй танилцаж зааварчилга өгсөн байна.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд хэрэгжиж байгаа “Англи хэл-30 хором” аяны хүрээнд алба хаагчдаас англи хэлний түвшин тогтоох шалгалтыг авч, анхан, дунд шатанд хувааж аймгийн Албан бус боловсролын газартай гэрээ хийсний үндсэн дээр англи хэлний сургагч багшийг урьж төвийн алба хаагчдад Долоо хоногийн Даваа, Мягмар гарагуудад 18,00-20,00 цагийн хооронд сургалтыг явуулж байна. Сургалтын явц, үр дүнгийн талаар 1 удаа түвшин тогтоох шалгалт авч үнэлж дүгнэсэн. Сумдын хэсгийн төлөөлөгч, цагдаа нарт гадаад хэлний мэдлэгээ дээшлүүлэх, бие даан суралцах, өөрийгөө хөгжүүлэх чиглэлээр бичгээр үүрэг өгч хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөц, сургалтын хэлтэс, Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвөөс зохион байгуулсан “Хүний эрхийн сургагч багш бэлтгэх давтан сургалт”-д Мөрдөн байцаах тасгийн дарга, цагдаагийн хошууч Л.Эрхзаяа, мөрдөгч, цагдаагийн ахмад С.Эрдэнэбилэг, “Цагдаагийн алба хаагчийн биеийн хүч, тусгай техник хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх, бэлтгэх” сэдэвт сургагч багш бэлтгэх сургалтад хэв журмын ажил хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн хошууч А.Учрахбаяр, С.Болдбаатар нар хамрагдсан.

Монгол улсад Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх төслийн хүрээнд “Жендерт суурилсан хүчирхийллийн судалгаа” сэдэвт сургалтад 9, “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” сэдэвт чадавхжуулах сургалтад 7 алба хаагч тус тус хамрагдсан.

Цагдаагийн ерөнхий газрын дэд даргын 2019 оны Б/08 тоот тушаалаар Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төв, Имако институттай хамтран “Ёс суртахуун-

төлөвшлийн сургалт"-ыг Зуунмод суманд зохион байгуулж, сахилгын зөрчил гаргасан 19 алба хаагчийг хамруулж сертификат гардуулсан.

Энэ онд тус газарт шинээр томилогдсон 24 алба хаагчид цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код-944/ "Дасан зохицох хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг хангах, ажлын байранд богино хугацаанд сурган дадлагажуулах зорилгоор сургагч багш нарыг тушаалаар томилж, сургалтын явц, үр дүнгийн талаар Цагдаагийн газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, үүрэг, ажлын чиглэл өгч хэрэгжилтийг хангуулсан.

Алба хаагчдын албаны бэлтгэжилтийг хангах, бие бялдрын өв тэгш хүмүүжил олгох зорилгоор Долоо хоног бүрийн Пүрэв гарагт 18.00-20.00 цагт чөлөөт тоглолт, бүжгийн "Шинэ одод" клубтэй хамтран тасаг бүрээс 3, нийт 20 алба хаагчийг гэр бүлийн хүний хамт бүжгийн спортоор хичээллүүлэх, Долоо хоног бүрийн Лхагва гарагт өглөө 06.00-07.00 цагийн хооронд "Нарны алхалт"-д алхуулж эрүүл мэндийг хамгаалах, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөхөд анхаарч ажиллаж байна.

*-Алба хаагчдын нийгмийн асуудал, үүрэг гүйцэтгэх нөхцөл, боломжийг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний талаар:*

Аймгийн Засаг даргын тамгын газрын албан тушаалын байранд 4 алба хаагчийг, Цагдаагийн газрын нийтийн эзэмшлийн орон сууцанд 7 алба хаагчийг гэрээ байгуулан оруулж нийгмийн асуудлыг шийдвэрлэж ажилласан. Алба хаагчдаас гарсан санал хүсэлтийн дагуу 30 айлын орон сууц барих ажлыг зохион байгуулж газрын асуудлыг нутгийн захиргааны байгууллагад уламжлан шийдвэрлүүлж улмаар Зуунмод сумын Манзушир өргөө хороололд орон сууц барих барилгын ажлыг "Ирксиб Строй" ХХК-аар гүйцэтгүүлсэн. Барилгыг 7 сард улсын комисст хүлээлгэн өгөхөөр төлөвлөөд байна.

Алба хаагчид, тэдний гэр бүлийн хүмүүсийг хөгжүүлэх чиглэлээр Хөгжлийн өргөөг шинээр барьж тохижуулан, алба хаагчдын хүүхдүүдэд дугуйлан хичээллүүлэх, "Англи хэл-30 хором" аяны хүрээнд сургалт явуулахад ашиглаж байна. Уг "Хөгжлийн өргөө"-нд шинээр тавцантай сандал 25 ширхэг, самбар 1 ширхэг, ус буцалгагч 1 ширхэгийг тус тус байрлуулсан. Алба хаагчдын санаачилгаар Цагдаагийн газрын сургалтын зааланд засвар хийн, шинээр 75 ширхэг сандал, 20 ширхэг ширээ, 1 ширхэг зурагт байрлуулж, сургалт явагдах орчинг бүрдүүлсэн.

Алба хаагчдын ажлын байрны нөхцөлийг сайжруулах зорилгоор Мөрдөн байцаах албаны ашиглаж байсан, цаашид ашиглаж болохуйц сейф 4, ширээ 16, сандал 16 ширхэгийг авчирч алба хаагчдын албан хэрэгцээнд олгосон.

Тус аймгийн Сэргэлэн сумын 4 дүгээр баг Их майдар гэх газарт алба хаагчид, ахмад ажилтнуудын хувийн хэрэгцээнд зориулан нэг айлын 0,7 га хэмжээ бүхий 200 айлын газрыг сумын Засаг даргын тамгын газартай хамтран шийдвэрлүүлж, эзэмшлийн гэрчилгээг олгуулсан.

Цагдаагийн газрын хашаанд нараар цэнэглэгддэг гэрэл 12 ширхэг, прожуктор 7 ширхэгийг тус тус байрлуулан байгууллагын гэрэлтүүлгийг шинэчилсэн. Цагдаагийн газрын төв байрны урд хананд "Цагдаагийн лого болон 98" гэсэн бичиглэлийг хөөсөөр 5\*5 хэмжээтэй хийлгэн тогтоож, ногоон байгууламжийг 100 хувиар нэмэгдүүлсэн. "Бүх нийтээр мод тарих өдөр" буюу 05 дугаар сарын 11-ний өдөр алба хаагчид ажиллаж

буй орчиндоо 300 ширхэг модны суулгац, 500 ширхэг мандлын цэцгийн үрсэлгээ тарьсан.

Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын хэмжээнд хэрэгжиж буй “Эрүүл цагдаа” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд алба хаагч, тэдний гэр бүлийн хүмүүс эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх шинжилгээ өгөх тохиолдолд цалинтай чөлөө олгож байхаар байгууллагын дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулсан ба энэ онд эрүүл мэндийн шинжилгээ өгөхөөр 12 алба хаагч хүсэлт гаргасны дагуу, Цагдаагийн газрын даргын тушаалаар 1-3 хоногийн хугацаатай цалинтай чөлөө олгосон.

Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар 24 цагаар хонож үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдад 5000 төгрөгийн халуун хоол цайгаар үйлчилж байна. Мөн 1530,0 мянган төгрөгийн үнэ бүхий ус цэвэршүүлэгч 1, 2 дугаар давхарт байрлуулсан.

Эхний хагас жилд 5 ширхэг таблет, 32 ширхэг бэлэн бус торгуулийн төхөөрөмж, хэвлэгчийн хамт ЦЕГ-аас авчирч алба хаагчдын албан хэрэгцээнд тарааж олгосон. 1 ширхэг компьютерийг Эрүүгийн цагдаагийн тасагт өгч, ЦЕГ-ын СААА-д хүсэлт гарган 2 ширхэг компьютер авахаар шийдвэрлүүлсэн.

Цахим архив үүсгэхтэй холбогдуулан 1650,0 мянган төгрөгийн архивын скайнерыг архив хариуцсан алба хаагчид өгсөн байна.

*Нутаг дэвсгэрийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргаар уламжлан шийдвэрлүүлсэн ажил, арга хэмжээ, төсөв хөрөнгө, зарцуулалт, үр дүнгийн талаар:*

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн 2019 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн хурлын 28 тоот тогтоолоор Алтанбулаг, Зуунмод, Баянхангай, Лүн, Баян зэрэг 5 суманд нэмж олон нийтийн цагдаагийн ажилтан ажиллуулахаар шийдвэрлүүлэн дээрх сумдад ажиллах хүсэлт гаргасан иргэдийг Цагдаагийн ерөнхий газрын сургалтын нэгдсэн төвд олон нийтийн цагдаагийн сургалтанд хамруулан сертификат олгож томилуулан ажиллуулж байна. Олон нийтийн цагдаагийн ажилтны сарын урамшууллыг дээрх сумдын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах сумын зөвлөлөөс хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр буюу 340.000 төгрөгийн урамшууллыг сар бүр шийдвэрлүүлэхээр сумдад албан тоотыг хүргүүлж шийдвэрлүүлсэн. Одоогийн байдлаар 14 суманд Олон нийтийн цагдаагийн ажилтан ажиллахаас 12 суманд ажиллаж байна. Эрдэнэсант, Баянхангай суманд олон нийтийн цагдаа ажиллаагүй байна

Сум орон нутагт ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчийн орон байр, тээврийн хэрэгсэл, нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд Алтанбулаг, Батсүмбэр, Мөнгөнморьт, Сэргэлэн сумдын Засаг даргын тамгын газраас цагдаагийн хэсгийн төлөөлөгчийн байр /кобан/-ны урсгал засварт 3,7 сая төгрөг, Баянцагаан, Дэлгэрхаан сумдын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил зохицуулах зөвлөлөөс 9,5 сая төгрөгийн согтуурал хэмжигч багаж, бэлэн бус торгуулийн төхөөрөмж, Алтанбулаг, Аргалант, Эрдэнэ сумд хэсгийн төлөөлөгчийн авто машины засварт 14,5 сая төгрөг, Баянхангай, Эрдэнэсант сум 24,0 сая төгрөгийн өртгөөр 2 суудлын авто машин, Баянчандмань сумын Замын цагдаагийн постод 8,0 сая төгрөгөөр их засвар хийсэн байна.

Сумдын Засаг дарга, хэсгийн төлөөлөгч, цагдаагийн газрын дарга нартай байгуулсан гурвалсан гэрээний дагуу Алтанбулаг, Баяндэлгэр, Баянжаргалан,

Баянцагаан, Дэлгэрхаан, Жаргалант сумд алба хаагчдын хүнсний хэрэгцээнд 10 хонь олгож. Архуст, Эрдэнэ, Борнуур, Сэргэлэн, Сүмбэр сумдын удирдлагаас хэсгийн төлөөлөгч, цагдаа нарын гэр бүлийн 5 хүнийг ажлын байраар хангаад байна.

Түр хамгаалах байрны дээврийн засварын ажилд аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлөөс 1,500,000 төгрөгийн хөрөнгийг шийдвэрлүүлж дээврийн засварын ажил хийгдэж байна.

Цагдаагийн байгууллагын чиг үүрэгтэй холбоотой бусад төрийн болон төрийн бус байгууллагаас хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрт хамрагдаж байгаа болон бие даан хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, хугацаа, үр дүнгийн талаар:

Хүүхэд хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөр 2017-2021 он, Архидалтын эсрэг-Төв аймаг хөтөлбөр 2018-2022 он, Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр 2019-2023 он, Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр 2018-2022 он хүртэл хэрэгжиж байна. Хүүхэд хөгжил хамгаалал үндэсний хөтөлбөрийн хүрээнд Цагдаагийн газраас нийт 5 зорилтын хүрээнд 18 ажил үйлчилгээг төлөвлөн хэрэгжилт нь 88,5 буюу В үнэлгээтэй үнэлэгдсэн байна.

Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ:

Тус цагдаагийн газрын даргын 2018 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/39 дүгээр тушаалаар байгууллагын хэмжээнд “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”, Цагдаагийн ерөнхий газрын “Авлигаас урьдчилан сэргийлэх салбар зөвлөл”-ийн хийх ажлыг төлөвлөгөөг хэрэгжүүлж, биелэлт үр дүнг тооцон ажиллах салбар зөвлөлийг 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.

Мөн газрын даргын 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн Б/07 дугаар тушаалаар “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг”, “Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг”-ийг тус тус бүртгэх, хадгалах, хяналт тавих, нэгтгэх ажил үүргийг Захиргааны удирдлагын тасгийн дарга, Хүний нөөцийн мэргэжилтэн нар хариуцсан ажиллаж байна.

Салбар зөвлөлөөс Цагдаагийн ерөнхий газрын дэд даргын 3/77 дугаар албан бичгээр ирүүлсэн ажлын чиглэлийн дагуу тус газрын 2 давхарт “Авлигатай тэмцэх үйл ажиллагааг сурталчлах самбар”-ыг байрлуулсан.

Авлигатай тэмцэх хууль, хөтөлбөрийг сурталчлах, ХАСХОМ мэдүүлэх аргачлалын талаар энэ оны 01 дүгээр улиралд алба хаагчдад 1 удаа, 2-р улиралд 2 удаа сургалт зохион байгуулж, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-өөр гарын авлага бэлтгэн ахлагч бүрэлдэхүүнд тараан, “Авлигаас ангид байх амлалтын дэвтэр”-т тэмдэглэл хийлгэсэн.

Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсэгт заасны дагуу 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс 02 дугаар сарын 15-ны өдрийн хугацаанд Төв аймаг дахь цагдаагийн газрын 109 алба хаагч хугацаа хоцроолгүй хөрөнгө орлогын мэдүүлгээ мэдүүлсэн байна. Шинээр томилогдсон болон шилжин томилогдсон 11 алба хаагчаас хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг хүлээн авч, хянан бүртгэсэн.

Цагдаагийн газрын 1 , 2 дугаар давхар, иргэдийн танхимд авлигын эсрэг зурагт хуудсууд, ил тод байдлын самбарыг байрлуулан алба хаагчид болон иргэдэд сурталчлан ажиллаж байна.

Цагдаагийн газрын нийт бие бүрэлдэхүүний дунд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд танин мэдэхүйн АХА тэмцээн зохион байгуулж, эхний 3 байрт шалгарсан алба хаагчдыг цалингийн хувиар урамшуулсан байна.

*Алба хаагчдын сахилга хариуцлага, ёс зүйн чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээний талаар:*

Цагдаагийн газрын даргын 2018 оны 03 дугаар 27-ны өдрийн А/26 дугаар тушаалаар “Сахилга ёс зүйн зөвлөл”-ийг Захиргааны удирдлагын тасгийн даргаар ахлуулан 8 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй байгуулж, улирал бүр хуралдан, сахилга ёс зүйн байдалд дүн шинжилгээ хийн ажиллаж байна.

Сахилга ёс зүйн зөвлөлөөс 2019 онд сахилга хариуцлагын зөвлөгөөнийг нэгдсэн байдлаар 3, хэсэгчилсэн байдлаар Заамар, Лүн сумдад 2 удаа, сахилга хариуцлагатай холбоотой сургалт 3, илтгэлийн уралдаан 2 удаа тус тус зохион байгуулж, сахилгын зөрчил гаргасан 25 алба хаагчид ажиллах урам зоригийг сэргээсэн, урмын үгтэй “Итгэл найдварын захидал” гардуулж, дахин алдаа дутагдал гаргахгүй ажиллах талаар хамт олны өмнө амлалт авхуулан нөлөөллийн арга хэмжээг явуулсан.

Дээрх зөвлөгөөнүүдэд давхардсан тоогоор 350 алба хаагч хамрагдсан ба зөвлөгөөн зохион байгуулсан талаарх мэдээллийг Цагдаагийн газрын цахим хуудсанд байршуулж, албан бичгээр Цагдаагийн ерөнхий газрын Аюулгүй байдлын хэлтэст хүргүүлсэн

Цагдаагийн ерөнхий газрын дэд даргаас энэ онд ирүүлсэн 3/73 дугаар үүрэг, ажлын чиглэлийн дагуу алба хаагчийн сахилга ёс зүйг сайжруулах, өргөсөн тангарагтаа үнэнч байж, бусдын нэр төр, алдар хүндийг хүндэтгэж, шударга, зарчимч, ёс зүйтэй, шуурхай, мэргэшсэн үйл ажиллагааг хэвшүүлэх чиглэлээр Цагдаагийн газрын дарга Цагдаагийн ерөнхий газрын дэд даргатай, Цагдаагийн газрын дарга тус газрын 190 алба хаагчтай тус тус 2019 оны 03 дугаар сард “Итгэлцлийн гэрээ”-г байгуулсан ба гэрээний хэрэгжилтэд өдөр тутам хяналт тавин ажиллаж байна.

Тус газрын 180 алба хаагчид Засгийн газрын 2017 оны 01 дүгээр албан даалгавар, 2018 оны 258 дугаар тогтоол, Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм, сахилгын дүрэм, Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2019 онд дэвшүүлсэн зорилт, зорилтын тайлбар, зорилтыг хэрэгжүүлэх шалгуур үзүүлэлт, ЦЕГ-ын даргаас удирдах ажилтны зөвлөгөөнд өгсөн үүрэг, байгууллагын дотоод журмыг нэгтгэсэн гарын авлагыг бэлтгэн тараасан.

Энэ онд тус газарт шинээр томилогдсон 24 алба хаагчид байгууллагын лого бүхий жагсаалын үзлэгийн ком, Цагдаагийн алба хаагчийн сахилга, ёс зүйн дүрмийг багтаан хэвлэсэн сургалтын дэвтэрийг хамт олны өмнө хүндэтгэлтэйгээр гардуулан, ажлын амжилт хүссэн. Алба хаагчдыг сахилгын зөрчил гаргахаас урьдчилан

сэргийлэх зорилгоор 156 алба хаагчаас сахилгын зөрчил гаргахгүй талаар баталгаа гаргуулан авсан байна.

Цагдаагийн газрын 1 давхарт цахим нүүр, хурууны хээгээр цаг бүртгэдэг программыг байрлуулан цаг бүртгэж байна. Тус газрын албан хаагч, ажилтан ажлын цагаар албан байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг хориглох заалтыг байгууллагын дотоод журамд оруулан баталж, тогтоол, дотоод журмын биелэлтэд тус газрын Ёс журам сахиулах эргүүлүүд, тасаг, хэсгийн дарга нар, Байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангах орон тооны бус ажлын хэсгээс хяналт тавьж, шалгалтыг тогтмол хийж байна.

Алба хаагчдын сахилга хариуцлагыг сайжруулах, төлөвшүүлэх, харилцааны соёлыг дээшлүүлэх, ахмад, дунд, залуу үеийн залгамж холбоог хөгжүүлэх, ахмадаас суралцах зорилгоор Цагдаагийн ерөнхий газрын дарга асан, хошууч генерал Б.Пүрэв, Боловсон хүчний асуудал эрхэлсэн дэд даргаар ажиллаж байсан цагдаагийн бэлтгэл дэд хурандаа С.Дашдорж, цагдаагийн бэлтгэл ахмад Л.Хуягбаатар, Зууны манлай замын байцаагч, цагдаагийн бэлтгэл дэд хурандаа А.Чумхаан нарыг урьж, уулзалт, ярилцлага зохион байгуулсан нь алба хаагчдын ажилд хандах хандлага, идэвх санаачилгыг өрнүүлсэн, ахмадуудаас суралцсан үр дүнтэй арга хэмжээ болсон.

Сар бүр бусдыгаа манлайлан сайн ажилласан алба хаагчдыг “Сарын шилдэг” алба хаагчаар шалгаруулан, цахим хуудсаар сурталчилж, сарын үндсэн цалинг 20 хувиар нэмж шагнаж урамшуулж байна. Мөн Цагдаагийн газрын үйл ажиллагааг цахим хуудсаар идэвхтэй сурталчилсан 4, хамгийн итгэл даах 1, хамгийн тусч 1 алба хаагчийг тус тус шалгаруулан, батламж хадгалуулсан

Тус газрын дэд дарга, тасаг, хэсгийн дарга, ахлах албан тушаалтнуудын ажлын арга барил, ёс зүйн чиглэлээр 9 асуулт бүхий санал асуулгын хуудсыг алба хаагчдаас авч дүнг нэгтгэхэд зан харьцаа, ёс зүйн доголдолтой дарга, ахлахын талаар мэдээлэл ирээгүй ба алба хаагчид удирдлагын зүгээс сэтгэл зүйн дарамтгүй, тохилог орчинд албан үүргээ гүйцэтгэж байгаа талаар дүгнэлт гарсан байна.

2019 оны эхний хагас жилийн байдлаар 25 алба хаагч сахилгын зөрчил гаргаснаас офицер 20, ахлагч 5 байна. Сахилгын зөрчил гаргасан алба хаагчдын тоог өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12 нэгжээр буюу 48 хувиар өссөн үзүүлэлттэй, сахилгын арга хэмжээ авагдсан алба хаагчид нийт бүрэлдэхүүний 12 хувийг, үүнээс офицер бүрэлдэхүүн 9,6 хувийг эзэлж байна. Зөрчлийг хэлбэрээр нь авч үзвэл ажлын хариуцлага алдсан 37,5 хувь, ЭХХШТХ тогтоомж зөрчсөн 16,6 хувь, зүй бус харьцсан 16,6 хувь, ёс зүй зөрчсөн 4,1 хувь байна. Сахилгын зөрчлийн 14 буюу 56 хувийг байгууллагын дотоод хяналтаар илрүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 71 хувиар өссөн байна.

Цагдаагийн ерөнхий газрын дэд даргаас 2018 онд ирүүлсэн үүрэг, ажлын чиглэлийн дагуу Прокурорын байгууллагаас ирүүлсэн шаардлага бүрийг Захиргааны удирдлагын тасгийн дарга бүртгэн, Шуурхай удирдлагын тасгийн дарга Цагдаагийн байгууллагын нэгдсэн санд шивж оруулж байна. Энэ онд тус газарт прокурорын шаардлага 9-г ирүүлсэн ба шаардлага тус бүрд заагдсан зөрчилд албаны шалгалт явуулж, зөрчил заагдсан алба хаагчдад албаны шалгалт явуулан хариуцлага тооцсон.

Аймгийн эрүүл мэндийн газартай хамтран “Ахлагч бүрэлдэхүүний сургалт, цугларалт”-ын үеэр 50 алба хаагчийг нарийн мэргэжлийн шинжилгээнд хамруулж, 35-

аас дээш насны 18 алба хаагчийг зүрх судас, эхо, рентгенд харуулж, нарийн мэргэжлийн эмч нарт үзүүлсэн.

Цагдаагийн ерөнхий газрын дэд даргын 2019 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн Б/08 тоот тушаалаар Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төв, ИМАСО институттэй хамтран “Ёс суртахуун-төлөвшлийн сургалт”-ыг энэ оны 06 дугаар сарын 22, 23-ны өдрүүдэд Зуунмод суманд зохион байгуулж, сахилгын арга хэмжээ авагдсан 19 алба хаагч 8 багц сэдвийн хүрээнд 12 цагийн сургалтад, мөн 3 алба хаагч Тээврийн цагдаагийн албанд энэ сарын 24, 25-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Мэргэжлийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх сургалт”-д тус тус хамрагдсан.

“Цагдаагийн алба хаагчийн харилцааны соёлыг дээшлүүлэх дэд хөтөлбөр”, “Эерэг хандлагыг төлөвшүүлье” аяны хүрээнд “Сахилга хариуцлагыг дээшлүүлье”, “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын сахилга, ёс зүй, аюулгүй байдлыг сайжруулах, авлигын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх” сэдэвт илтгэлийн уралдааныг 2 удаа зохион байгуулж, 21 алба хаагч илтгэл хэлэлцүүлж, эхний 3-н байранд шалгарсан 6 алба хаагчийн сарын үндсэн цалинг 10-20 хувь нэмэгдүүлэхээр шийдвэрлэж батламж хадгалуулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 01 тоот албан даалгавар, 2018 оны 258 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх чиглэлээр тус газраас 2019 онд хийх ажлын төлөвлөгөөг гарган, хэрэгжилт үр дүнг тооцон ажилласнаар 2019 эхний хагас жилийн байдлаар албан даалгавар, тогтоолын хэрэгжилт 98,5 хувьтай дүгнэгдсэн байна.

#### Санхүүгийн үйл ажиллагааны чиглэлээр:

Цагдаагийн газар 2019 оны эхний хагас жилд 1,6 тэрбум төгрөгийн санхүүжилт авч байгууллагын үйл ажиллагаа хэвийн явагдах нөхцөлийг бүрдүүлж ажиллаж байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогоор 8,1 сая төгрөгийг бүрдүүлсэн. Торгуулийн орлогоор аймаг орон нутгийн төсөвт 144,0 сая төгрөгийг төвлөрүүлсэн.

Цагдаагийн газрын 2018 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Төрийн Аудитын газраар аудит хийлгэн зөрчилгүй дүгнэлт авсан. Аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг гарган холбогдох материалын хамт аймгийн Төрийн Аудитын газар, СААА-д тус тус хүргүүлсэн. 2018 оны тайлангийн нэгтгэлийг ЦЕГ-ын СААА-д 01 сарын 18-наас 01 сарын 25-ны хооронд нэгтүүлж Авто бааз, Захиргааны удирдлагын газар, Хангалт үйлчилгээний төв, Тээврийн цагдаагийн албадтай тооцоо нийлж ажилласан байна. 2019 оны 1 дүгээр улирлын тайланг хугацаанд нь ЦЕГ-ын СААА-д хүргүүлсэн. Сар бүр төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, өр авлагын мэдээг гаргаж аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээр баталгаажуулан ЦЕГ-ын СААА-д нэгтүүлж ажилласан. Үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээг Сангийн сайдын 173 дугаар тушаалын дагуу үнэн зөв хийж “Хан үнэлэмж” ХХК-аар нягтлан шалгуулж баталгаажуулсан. Орон нутгийн өмчийн газарт хөрөнгийн дахин үнэлгээний тайлан болон хөрөнгийн тайланг хянуулж нэгтгүүлсэн.

Цагдаагийн газрын тасаг, албадын 2018 оны баримтыг хадгаламжийн нэгж үүсгэн архивлахад 993,5 мянган төгрөгийн стандартын шаардлага хангасан архивын материалыг бэлтгэж олгосон. Сургалтын танхимын засварт 8,0 сая төгрөгийн материал авч засвар үйлчилгээг хийсэн. Тээврийн хэрэгслийн аюулгүй байдал, албаны бэлэн байдлыг хангах зорилгоор Цагдаагийн газрын автомашинуудад 7,5 сая төгрөгийн сэлбэг хэрэгсэл олгосон. Хагас жилийн байдлаар 84,6 сая төгрөгийн шатах

тослох материалыг дуудлага, хөдөлгөөнт эргүүл, жижүүр, хэрэг шалгахад зарцуулсан байна. Албан томилолтыг хийсэн ажлын гүйцэтгэлд үндэслэн 3,0 сая төгрөгийн зардлыг алба хаагчдад олгосон. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, худалдан авах ажиллагааны журмыг хэрэгжүүлэн аж ахуй нэгж байгууллагуудтай гэрээ байгуулан бараа материалыг бэлтгэн байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явагдах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.

Алба хаагчдын цалин хөлсийг цаг тухайд нь олгож, нийгмийн даатгалын шимтгэлийг дараа сарын 05-ны дотор нийгмийн даатгалын цахим сайтад шивж баталгаажуулж нийгмийн халамж, үйлчилгээнд хамрагдах боломжийг бүрдүүлж байна. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах Цагдаагийн газрын төсөв санхүүгийн талаар иргэдэд ил тод мэдээлэх зорилгоор 67 мэдээ мэдээллийг хугацаанд нь шилэн дансны цахим хуудсанд байршуулж нийт бие бүрэлдэхүүнд шилэн дансны цахим хуудсанд хандалт хийх талаар зааварчилга өгсөн ба аудитын дүгнэлт, санхүүгийн тайланг танилцуулж хэлэлцүүлж ажилласан.

Цагдаагийн газрын 2019 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг гарган tender.gov.mn сайтад байршуулсан. Байгууллагын 2019 оны худалдан авах ажиллагааны бичмэл болон хүснэгтэн тайланг гаргаж аймгийн Орон нутгийн өмчийн газар, СААА-д хүргүүлж ажилласан. 2020 оны төсвийн төсөл, 2021-2022 оны төсвийн төсөөллийг боловсруулж ЦЕГ-ын СААА-д хүргүүлсэн. Хамгаалалт, баяр наадмын төсвийг хийж холбогдох газруудад хүргүүлэн зардлыг шийдвэрлүүлж ажилласан.

Цагаан сарын шинийн 3-нд Цагдаагийн газарт ажиллаж байгаад цэргийн байнгын тэтгэвэрт гарсан 50 ахмадыг хүлээн авч хүндэтгэл үзүүлэн алба хаагчидтай нэгдсэн золголт хийх ажлыг зохион байгуулж ажилласан.

**Зохион байгуулсан шинэлэг, ажил арга хэмжээ, түүний үр дүнгийн талаар:**

Тус газрын 180 алба хаагчид Засгийн газрын 2017 оны 01 дүгээр албан даалгавар, 2018 оны 258 дугаар тогтоол, Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм, сахилгын дүрэм, Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2019 онд дэвшүүлсэн зорилт, зорилтын тайлбар, зорилтыг хэрэгжүүлэх шалгуур үзүүлэлт, ЦЕГ-ын даргаас удирдах ажилтны зөвлөгөөнд өгсөн үүрэг, байгууллагын дотоод журмыг нэгтгэсэн гарын авлагыг бэлтгэн тараасан.

Алба хаагчдыг бүсийн зохион байгуулалтад оруулан цагдаагийн газрын даргын тушаалаар 4 бүс болгон хувааж хариуцсан бүсээр ажиллуулж байгаа нь алба хаагчдыг сум, орон нутгийн онцлогтой танилцуулсан, бусдаас суралцах нөхцөл боломжийг бүрдүүлсэн, хамтач багаар ажиллах чадварыг нэмэгдүүлсэн үр дүнтэй шинэлэг ажил болоод байна. Мөн шинэчлэн батлагдсан хууль тогтоомжийн талаар нэг мөр ойлголттой болох, хууль хяналтын байгууллагын ажлын уялдаа холбоог сайжруулах зорилгоор аймгийн прокурорын газартай хамтарсан зөвлөгөөнийг сар бүр хийж алба хаагчдын шалгаж байгаа эрүүгийн хэрэг, иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээллийг хариуцсан тасгийн дарга, ахлахууд, хяналтын прокурорын хамт танилцан үүрэг, зааварчилга өгч тулгамдаж байгаа асуудлын талаар харилцан ярилцан шийдвэрлэж байгаа нь хууль хяналтын байгууллагын ажлын уялдаа холбоог сайжруулсан үр дүнтэй ажил болсон.

Цагдаагийн ерөнхий газрын дарга асан, хошууч генерал Д.Пүрэв, Боловсон хүчний асуудал эрхэлсэн дэд даргаар ажиллаж байсан цагдаагийн бэлтгэл дэд хурандаа С.Дашдорж, цагдаагийн бэлтгэл ахмад Л.Хуягбаатар, Зууны манлай замын байцаагч, цагдаагийн бэлтгэл дэд хурандаа А.Чумхаан нарыг урьж нийт бие

бүрэлдэхүүнтэй “Уламжлал ба шинэчлэл” уулзалт ярилцлагыг 3 удаа зохион байгуулсан.

“Эерэг хандлагыг төлөвшүүлье” 45 хоногийн аяныг зарлаж аяны хүрээнд алба хаагчдын дунд “Хамт олондоо талархъя”, “Шинэ санал санаачилгыг дэмжье” арга хэмжээ зохион байгуулж, “Талархлын хайрцаг”, “Шинэ санал санаачилгын хайрцаг”-ийг аялуулснаар 36 алба хаагч 17 алба хаагчид хандан бичгээр талархал илэрхийлж, 4 алба хаагчаас 6 шинэ санал санаачилга ирсэн.

Алба хаагчдын дунд зохион байгуулсан “Ээждээ захидал бичээрэй” уралдааны шалгарсан захидлаар 3 удаа, “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын ахмад, дунд, залуу үеийн залгамж холбоог хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд ахмад ажилтнуудтай хийсэн уулзалт, ярилцлага, сургамж, үг, захиасаар 2 удаа, алба хаагчдын гэр бүлд чиглэсэн “Итгэл найдварын захидал”-аар 1 удаа, нийт 6 богино хэмжээний видео бэлтгэж албаны сургалтын цагаар бие бүрэлдэхүүнд үзүүлж, Төв аймгийн цагдаагийн газар фейсбүүк хаягт байрлуулж иргэд, олон нийтэд сурталчилсан.

### Бусад ажлын талаар:

Цагдаагийн газрын алба хаагчдын дунд “Дээлтэй Монгол өдөрлөг”, “Эерэг хандлагыг төлөвшүүлье” 45 хоногийн аян, Монголын уламжлалт “Сар шинэ”-ийн баярыг тохиолдуулан Цагдаагийн газрын ахмад ажилтнуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ, Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг угтаж “Мөрдсөөрөө гоёсон бүсгүй”, “Монита” арга хэмжээ, “Ээждээ захидал бичээрэй” уралдаан, “Сахилга, хариуцлагыг дээшлүүлье” илтгэлийн уралдаан, Монгол цэргийн өдрийг угтаж Төв аймгийн Засаг даргын нэрэмжит “Марш тактикийн аварга тасаг шалгаруулах тэмцээн”, “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын ахмад, дунд, залуу үеийн залгамж холбоог хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд “Уламжлал ба шинэчлэл” уулзалт ярилцлага, “Стрессгүй өдөр” өдөрлөг, “Монголын нууц товчоонд нэвтрэхгүй”, яруу найргийн “Цагаан шонхор” тэмцээн, “Эрүүл агаар эм” явган болон дугуйтай аялал, “Уран жолоодлогын тэмцээн”, “Тохилог ажлын байр” болзолт уралдаан, “Цэрэгжилт, жагсаалч алба хаагч” шалгаруулах зэрэг арга 96 удаагийн арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор 17888 алба хаагч хамрагдсан байна.

Тус Цагдаагийн газраас Цагдаагийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 дахь хэсэг, Хууль зүйн сайдын 2014 оны А/89 дүгээр тушаалаар баталсан “Иргэний зөвлөл, оршин суугчдад цагдаагийн байгууллагын тайлан тавих журам”-ын дагуу 2018 оны үйл ажиллагааны тайланг тавьж, аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил зохицуулах зөвлөлийн дэргэдэх Иргэний зөвлөлийн гишүүд урилгаар оролцсон. Тайлангийн хуралд 200 гаран иргэн хамрагдаж 13 иргэнээс 20 санал шүүмжлэл ирүүлснийг цагдаагийн газрын удирдлага хүлээн авч газар дээр нь хариуг нь өгсөн.

Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн бэлтгэлийг хангаж, Төв аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран байгууллагынхаа хэмжээнд явуулах урьдчилсан үзлэгийг хийж 90 хувьтай дүгнэгдсэн. Байгууллагын архивын хадгаламжийн нэгжийн бодит тоог тогтоох, тоо бүртгэлийн баримт бичигт тусгагдсан тоотой тохирч буй эсэхийг шалгах, механик болон биологийн гэмтлээс урьдчилан сэргийлэх, сэлбэн засах шаардлагатай баримт болон данс бүртгэлд ороогүй хадгаламжийн нэгжийг илрүүлэх зорилгоор “Архивын баримтад тооллого явуулах ажлын хэсэг”-ийг Цагдаагийн газрын даргын 2019 оны А/25 дугаар тушаалаар байгуулж тооллогыг явуулсан.

Засгийн газрын 2006 оны 64 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд байгууллагын архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх зорилгоор байгууллагын архивт хадгалагдаж байгаа 2016-2018 оны байнга хадгалах баримтыг 100 хувь цахим хэлбэрт шилжүүлсэн. Мөн Цагдаагийн газрын үйл ажиллагааны явцад үүссэн 2015 оны байнга хадгалах баримтыг нөхөн бүрдүүлэлтийн хуваарын дагуу 2019 оны 05 сарын 20-ны өдөр Цагдаагийн ерөнхий газрын Төв архивт хүргэхдээ захирамжлалын болон санхүүгийн баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, цаас болон цахим хэлбэрээр нөхөн бүрдүүлэлт хийсэн болно.

**Хоёр. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ**

Гэмт хэрэг илрүүлэх чиглэлээр: Тайлангийн хугацаанд нийт 201 шилжүүлэх материалаар 1,820,180,000 төгрөгний хохиролтой, 243 холбогдогчтой, 210 гэмт хэрэг үйлдлийг илрүүлснээс нөхөн илрүүлсэн 143, эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгуулахаар шилжүүлсэн 68 байна.

Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасгаас хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн даалгавар 77-г хүлээн авч даалгаварт заагдсан ажлыг хугацаанд нь хийж гүйцэтгэн хариуг өгсөн.

Хөтөлбөр албан даалгаварын хүрээнд:

*Зохион байгуулалттай бүлэг бөөгнөрлийн чиглэлээр:* Төв аймгийн нутаг дэвсгэрт бүртгэлтэй хорих ангиас суллагдсан 68, тус цагдан хорих байранд гэмт хэрэг үйлдэж хоригдон шалгагдаж байгаа 43, бусад аймгаас шилжин ирсэн, өмнө нь хорих ялаар шийтгүүлж суллагдсан 11, нийт 154 сэжигтэй этгээд мөн гэмт хэрэг үйлдсэн болон үйлдэж болзошгүй 7 бүлэг 29 сэжигтний дэлгэрэнгүй судалгааг баяжуулах зорилгоор арилжааны банк, үүрэн холбооны оператор компаниуд, улсын бүртгэлийн газар, авто тээврийн газар, хөдөлмөр халамж үйлчилгээний газар, нийгмийн даатгалын хэлтэс, хил хамгаалах ерөнхий газар зэргээс холбогдох бүртгэл судалгааг гаргуулан авч, дэлгэрэнгүй судалгааг ГА-ын эрхтэй алба хаагч нарт танилцуулж, бүртгэл судалгааг шинэчилсэн.

Эрүүл мэндийн сайдын 2015 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 68 тоот тушаалаар батлагдсан МУ-ын хүн амын эмчилгээнд хэрэглэх мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн жагсаалтанд орсон эмийг худалдан борлуулдаг иргэн, аж ахуй нэгжүүдийн дэлгэрэнгүй судалгааг шинэчлэн гаргах, тусгай зөвшөөрөл болон эм барих зөвшөөрөлтэй эсэхийг шалгаж аймгийн хэмжээнд нийт 78 эмийн сан үйл ажиллагаа явуулж байгаа ба үүнээс хувиараа эм зарж борлуулдаг 16 иргэн, аж ахуйн нэгжийн эмийн сан, сумдын эрүүл мэндийн төвийн гаднах 32 эмийн сан, сумдын эрүүл мэндийн төвийн доторх шаардлагатай чухал эм хэрэгсэл зарж борлуулдаг 29 эмийн сангуудад сумдын Засаг даргын тамгын газар, хэсгийн төлөөлөгч нараар дамжуулан хяналт шалгалтыг явуулсан.

Батсүмбэр, Борнуур, Жаргалант, Сүмбэр сумдад хар тамхины ургамлын төрөл болох хогийн олс /каннабис/-ын тархацтай ба дээрх сумдын хэсгийн төлөөлөгч нартай хамтран тархацыг тогтоон “Устгал” арга хэмжээг зохион явуулахаар төлөвлөгөө гарган бэлтгэл ажлыг хангасан.

*Хүн худалдах, биеэ үнэлэхийг зохион байгуулах, Садар самуунтай холбоотой гэмт хэргийг таслан зогсоох урьдчилан сэргийлэх, гэмт хэргийг илрүүлэх чиглэлээр:* Аймгийн хэмжээнд “Хүн худалдах, биеэ үнэлэхийг зохион байгуулах, садар самуунтай холбоотой гэмт хэргийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй сэжигтэй байр, байгууламж, ийм төрлийн гэмт хэрэг үйлддэг сэжигтэй этгээдүүдийг олж тогтоон бүртгэл судалгаанд авах, хууль бус үйлдлийг таслан зогсоох илрүүлэх, эрүүгийн хариуцлагад татах зорилгоор 3 бүлэг 11 зүйл бүхий төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Хүн худалдаалах биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр алба хаагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхтэй холбоотойгоор “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхэд алба хаагчдын ур чадварыг дээшлүүлэх нь” сэдэвт сургалтыг нийт бүрэлдэхүүнд 1 удаа зохион байгуулсан.

*Түүх соёлын дурсгалт зүйл, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр:* Аймгийн хэмжээнд эртний булш, хиригсүр болоод түүх соёлын дурсгалт газар нийт 430-г бүртгэж фото зурагжуулан бүртгэл судалгаанд оруулан ажилласан.

Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт байрлах “Ээж хайрхан”, Төв аймгийн Борнуур сумын нутаг Далын ам гэх газарт байрлах “Аглаг бүтээлийн хийд”, Төв аймгийн Эрдэнэсант сумын нутагт Дархан цаазат “Батхаан” уул, Төв аймгийн Угтаал цайдам, Цээл, Жаргалант сумын хилийн заагт байрлах “Хүүлээ хаан” уул, Төв аймгийн Баян-Өнжүүл сумын нутагт байрлах “Зоргол хайрхан” уул зэрэг газруудыг нутгийн иргэд төдийгүй ард иргэд ихээр тахин шүтэж очиж байна.

Төв аймгийн хэмжээнд нийт 21 сүм хийд үйл ажиллагаа явуулж байгаа ба үүнээс буддын шашны чиглэлээр 11 хийд, христийн шашны чиглэлээр 9 сүм, лалын шашны чиглэлээр 1 сүм үйл ажиллагаа явуулж байгаагаас христийн шашны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа сүмүүд нь “Төр сүм хийд харилцааны тухай хууль”-ийн 9-р зүйлийн 1- дэх заалтыг /Сүм хийд байгуулах/ зөрчиж аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байна.

*Гадаадын иргэдийн чиглэлээр:* Төв аймгийн нутаг дэвсгэрт түр болон удаан хугацаагаар оршин суугаа гадаадын харъяат иргэн нийт 438 байгаагаас 305 буюу 69,6 хувь Бүгд Найрамдах Хятад Ард улсын иргэд, 45 буюу 10,2 хувь Герман улсын иргэн, 27 буюу 6,1 хувь Шинэ Зеланд улсын иргэн, 14 буюу 3,2 хувь Бүгд Найрамдах Солонгос улсын иргэд, 22 буюу 5 хувь БНИндонез улсын иргэд, Оросын Холбооны улсын иргэн 5, Казакстан улсын иргэн 2, Америкийн Нэгдсэн улсын иргэн 3, Япон улсын иргэн 6, Филиппин улсын иргэд 1, Ирланд улсын иргэн 2, Нидерландын Вант улсын иргэн 1, Ирланд улсын иргэн 2, Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант улсын иргэн 1, Канад улсын иргэн 1, Оросын холбооны улсын иргэн 5, харъяалалгүй хүн 1 байна.

ШШГЕГ-ын харъяа хорих ангид ял эдэлж байгаа гадаадын харъяат иргэн байхгүй.

2019 онд захиргааны зөрчилд холбогдсон гадаад улсын 43 иргэн бүртгэгдсэнээс БНХАУ-ын иргэн 36, Польш улсын иргэн 2, Шинэ Зеланд улсын иргэн 1, АНУ-н иргэн 1, Франц улсын иргэн 1, Австрали улсын иргэн 1, Чех улсын иргэн 1 байна.

Эрэн сурвалжлах ажлын чиглэлээр: Тус Цагдаагийн газрын алба хаагч нараас 2019 оны хагас жилийн байдлаар “ASAP” санд нийт 79 мэдээллийг зарлан мэдээлж, урьд онд болон энэ оны зарласан 124 хүн, мал, эд зүйлийн мэдээллийн эрэн сурвалжлалтыг зогсоосон.

Энэ оны эрэн сурвалжлах “ASAP” сангийн ашиглалт, бүрдүүлэлтийн явц байдал зарлан мэдээлсэн хүн, мал, эд зүйлийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 79 нэгжээр буюу 49,3 хувиар, олж тогтоож эрэн сурвалжлалт зогсоосон хүн, мал, эд зүйлсийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 36 нэгжээр буюу 22,5 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

2019 оны эхний хагас жилийн байдлаар иргэдээс оршин суугаа газраасаа алга болсон хүний талаар 9 өргөдөл, гомдол ирүүлснийг хүлээн авч эрэн сурвалжлах санд зарлан мэдээлж 8 хүнийг олж тогтоон эрэн сурвалжлалтыг зогсоон ажиллаж байна. Нийт санд оруулсан 79 мэдээллээс бүртгээгүй, хянагдаагүй, шаардлага хангаагүй мэдээлэл байхгүй, одоогоор эрэн сурвалжлах “ASAP” санд ямар нэгэн зөрчил байхгүй.

Тус цагдаагийн газрын эрүүгийн төлөөлөгч нараас эрэн сурвалжлалтын чиглэлээр гүйцэтгэх ажлын 39 мэдээ мэдээлэл авч санд оруулан шалган баримтжуулан оргодол 12, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд 18, оршин суугаа газраасаа алга болсон 8 хүнийг тус тус олж тогтоон эрэн сурвалжлалтыг зогсоосон.

“ASAP” сангийн ашиглалт бүрдүүлэлтийг сайжруулах, алба хаагч нарын мэдлэг чадварыг дээшлүүлэх чиглэлээр тайлангийн хугацаанд 2 удаа сургалт орж, урьд онуудад зөрчилтэй оруулсан 20 мэдээллийг сангаас шүүж зөрчлийг засаж одоогийн байдлаар эрэн сурвалжлах санд ямар нэгэн зөрчил байхгүй байна.

Эрэн сурвалжлах ажлыг эрчимжүүлэх, эрэн сурвалжлах ажлын үр нөлөөг дээшлүүлэх хөдөө сумдад ажиллаж байгаа хэсгийн төлөөлөгч, цагдаа нарт мэдээллийг шуурхай хүргэх зорилгоор “Төв ЦГ эрэн сурвалжлалт” нэртэй facebook хаяг нээн ажиллуулж байна.

Мал хулгайлах гэмт хэргийн нөхцөл байдлын талаар: Тайлангийн хугацаанд мал хулгайлах гэмт хэргийн шинжтэй 143 гомдол мэдээлэл ирснийг зохих журмын дагуу хүлээн авч 44 хувийг буюу 62-т эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж бүртгэгдэх үедээ сэжигтэн яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй 48 хэргээс 28 хэргийг илрүүлэн мал хулгайлах гэмт хэргийн илрүүлэлт 58.3 хувьтай байна.

Цагдаагийн газраас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мал хулгайлах гэмт хэргийн гаралтыг бууруулах, илрүүлэлтийг ахиулах зорилгоор аймгийн 27 сумыг 4 бүс болгон хувааж энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг шинэлэг хэлбэрээр зохион байгуулахын зэрэгцээ хил залгаа аймаг, дүүргийн цагдаагийн алба хаагч нартай хамтран ажиллаж бүлэг, зохион байгуулалттайгаар, аймаг, сум дамжин мал хулгайлах гэмт хэрэг үйлддэг 3 бүлэг, 13 этгээдүүдийг илрүүлэн баривчилж, хэргийг шалгаж шийдвэрлэсэн.

Иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай Монгол улсын хуулийн дагуу яриа таниулгыг давхардсан тоогоор 163 удаа 17500 орчим иргэд, малчдад хийж, аймгийн хэмжээнд мал хамгаалах малчдын 32 бүлэгт мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч, гэмт хэрэг илрүүлэх, гэмт хэргийн мэдээлэл авах, хамтран эргүүл шалгалтыг хийх зэргээр зохион байгуулсан.

**Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр:** Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Тагнуулын газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Татварын хэлтэс зэрэг байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулан хамтарсан шалгалтын ажиллагааг 3 удаа зохион байгуулсан.

Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх газрын Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх 5 дугаар хэлтсээс ирүүлсэн 09 тоот “Химийн хортой болон аюултай бодис”-ын талаар хийж гүйцэтгэх ажлын зааварчлагыг Төв аймгийн 27 сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган, хэрэгжилт үр дүнг тооцон ажилласан.

**Мөрдөн байцаах албаны чиглэлээр:**

2019 оны эхний хагас жилд иргэд байгууллагаас гэмт хэргийн шинжтэй 431 өргөдөл, гомдлыг хүлээн авч шалгаснаас хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн 188, шууд эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан 71, хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан 159, харъяаллын дагуу шилжүүлсэн 5, нийт 95,2 хувийг шийдвэрлэсэн. Одоо ажиллагаанд 8 гомдол мэдээллийн үлдэгдэлтэй байна.

Хэрэг бүртгэлтийн 275, мөрдөн шалгах 182 хэрэг нийт 455 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн шалгах ажиллагаа явуулсан нь өмнөх оны мөн үеэс 11.2 хувиар өссөн, нийт шалгасан хэргээс 199 хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлж, 128 хэргийг хэрэг бүртгэлтийн хэргийг хаах саналтай, 22 хэргийг бусад хэрэгт нэгтгэн, 8 хэргийг харъяаллын дагуу шилжүүлж, нийт мөрдөн шалгах ажиллагааны 357 хэрэг буюу 78.4 хувийг шийдвэрлэсэн. Мөрдөн байцаах тасаг нь тус газрын нийт шалгасан хэргийн 70 хувийг хуулийн хугацаанд шалгаж шийдвэрлэсэн ба бусад орон нутгаас ажлын үзүүлэлтээрээ эхний 3-т орсон байна.

Мөрдөгчийн мэдэгдэл 174 хэрэгт бичиж хариуг хугацаанд нь авсан, гэмт хэргийн улмаас нас барсан 51, гэмтсэн 148, гэмт хэргийн улмаас иргэд, байгууллагад 1.836.365.934 төгрөгийн хохирол учирснаас 1.582.699.374 төгрөгийг нөхөн төлүүлж хохирол нөхөн төлүүлэлт 86.1 хувьтай, эд хөрөнгө хураах ял болон иргэний нэхэмжлэлийг хангах зорилгоор 680.640.005 төгрөгийн эд хөрөнгийг битүүмжлэх ажиллагааг явуулжээ.

Тасгийн дарга, ахлах мөрдөгч нар мөрдөгч нарын шалгаж буй 378 хэргийг уншиж танилцаж, 82 хэрэгт даалгавар, зааварчилга бичиж 36 хэргийн газрын үзлэгт оролцож мэргэжлийн удирдлагаар хангаж багийн зохион байгуулалтад оруулахаас гадна ээдрээ төвөгтэй, ажиллагаа ихтэй болон бусад 42 хэрэгт ажлын хэсэг байгуулсан.

Төв аймгийн Прокурорын газартай хамтран сар болгон шийдвэрлэх хэргийн график гарган аймгийн прокурор, цагдаагийн газрын даргаар батлуулан, графикийн биелэлтэнд орлогч прокурор, тасгийн дарга, ахлах мөрдөгч нараас байнгын хяналт тавин, дараа сарын 5-ны дотор графикийн биелэлтийг тооцох, шийдвэрлэгдэхгүй удааширч байгаа хэргүүдийг шийдвэрлэх зорилгоор мөрдөгч, прокуроруудын хамтарсан зөвлөгөөнийг сар болгон хийж, алба хаагчдын ажлыг сайжруулах, эрчимжүүлэх чиглэлээр арга хэмжээг зохион байгуулж ажилласнаар хэргийн шийдвэрлэлт 86,6 хувьтай байна.

2019 оны эхний хагас жилд 382 гэмт хэргийн шинжтэй дуудлага, мэдээлэл хүлээн авснаас 74 дуудлага буюу 19 хувь нь аймгийн төвд, 81 хувь нь бусад сумдад буюу 18 км-ээс 220 км зайтай сумдад үйлдэгдэж мөрдөгч нар хөдөө, орон нутаг, алслагдсан газар мөрдөн шалгах ажиллагааг явуулж байна.

### **Хэрэг бүртгэх албаны чиглэлээр:**

Шийдвэрлэсэн зөрчлийн хэрэг, гомдол мэдээллийн талаар: Тус тасаг нь 2019 оны эхний 05 сарын байдлаар гэмт хэргийн шинжтэй 118, харъяаллын дагуу шилжиж ирсэн 20 гомдол мэдээлэл хүлээн авч шалгаснаас 14 гомдол мэдээллийг эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татаж, 75 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 44 гомдол мэдээллийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналтай шийдвэрлэж, 5 гомдол мэдээллийн үлдэгдэлтэй байна.

2019 онд шинээр хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн 75 урьд оны үлдэгдэл 12, урьд оны хэргээс сэргээсэн 14, нийт 115 хэрэгт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулснаас 71 хэргийг эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татаж, 14 хэрэг бүртгэлтийн хэргийг хаах саналтай шилжүүлж, 16 хэргийн үлдэгдэлтэй байгаагаас хугацаа сунгасан хэрэг 3 байна.

Мөрдөн байцаалтын 86 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж 86 хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай шилжүүлж, одоо мөрдөн байцаалтын хэргийн үлдэгдэлгүй байна.

2019 оны эхний 05 дугаар сарын байдлаар Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11 дүгээр бүлэгт заасан гэмт хэрэг 89 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10 буюу 12,6 хувиар өссөн, хэргийн шийдвэрлэлт урьд оны мөн үетэй харьцуулахад 17 хэрэг буюу 24,6 хувиар өссөн байна.

Гэмт хэргийн улмаас иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 81,480,000 төгрөгийн хохирол учирсанаас 68,430,000 төгрөг буюу 83,9 хувийн хохирлыг нөхөн төлүүлсэн.

### **Шуурхай удирдлагын албаны чиглэлээр:**

Тус газар нь 2019 оны эхний 06-р сард нийт 1594 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас гэмт хэргийн шинжтэй 657 буюу 41,2 хувь, зөрчлийн шинжтэй 937 буюу 58,8 хувийг шийдвэрлэсэн ба үүнээс гэмт хэргийн болон зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 1545 буюу **96,9 хувийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн** байна.

Нийт гомдол, мэдээллийн 49 буюу 3,1 хувь нь шийдвэрлэгдээгүй буюу хуулийн хугацаанд шалгагдаж байна. Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 599 буюу 91,2 хувийг 0-5 хоногт, 28 буюу 4,3 хувийг 6 ба түүнээс дээш хоногт, захиргааны зөрчлийн шинжтэй гомдол мэдээллийн 837 буюу 89,3 хувийг 0-3 хоногт, 81 буюу 8,6 хувийг 4 ба түүнээс дээш хоногт тус тус шийдвэрлэсэн байна.

Тус газрын хэмжээнд 2019 оны эхний 06 дугаар сарын байдлаар 172 холбогдогчтой, 2,276,300,000 төгрөгний хохиролтой **360** гэмт хэрэг бүртгэгдэн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 90 хэргээр буюу **25,0** хувиар өссөн байна.

Хөнгөн гэмт хэрэг 288 бүртгэгдсэн нь 88 нэгжээр буюу 30,6 хувиар, хэрэг бүртгэлтийн гэмт хэрэг 295 бүртгэгдэж 70 нэгжээр буюу 23,7 хувиар, мөрдөн

байцаалтын гэмт хэрэг 65 бүртгэгдэж 20 нэгжээр буюу 30,8 хувиар, хүнд гэмт хэрэг 72 бүртгэгдэн өмнөх оны мөн үеийнхээс 2 нэгжээр буюу 2,8 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Гэмт хэрэгт 172 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 50 хүнээр буюу 29,1 хувиар өссөн бөгөөд үүний 25 буюу 14,5 хувийг эмэгтэй, 147 буюу 85,5 хувийг эрэгтэй хүн эзэлж байна.

Гэмт хэргийн үйлдэгдсэн байдлаас үзэхэд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 21,6 хувиар, бүлэглэн үйлдсэн гэмт хэрэг 47,5 хувиар, эмэгтэй хүн оролцсон гэмт хэрэг 52,0 хувиар тус тус өссөн, галт зэвсгээр үйлдэгдсэн гэмт хэрэг 50,0 хувиар, хүүхэд оролцсон гэмт хэрэг 42,9 хувиар, гэр бүлийн хүчирхийлийн эсрэг гэмт хэрэг 9,1 хувиар, аймгийн төвд үйлдэгдсэн гэмт хэрэг 5,1 хувиар буурсан байна.

Гэмт хэргийн төрөл хүснэгтэд авагдсан судалгаанаас үзэхэд хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг, хүний эрүүл мэнд халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, залилах гэмт хэрэг, эд хөрөнгийг устгаж гэмтээх гэмт хэрэг, бусдын эд хөрөнгийг устгах, гэмтээх, үрэгдүүлэх гэмт хэрэг, мал хулгайлах гэмт хэрэг, эдийн засгийн эсрэг гэмт хэрэг, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг, хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг, авлигын эсрэг гэмт хэрэг, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг зэрэг гэмт хэрэг, цэргийн албаны эсрэг гэмт хэргүүд 11,2-100,0 хувиар өссөн, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, хулгайлах гэмт хэрэг, хувийн өмчийг хулгайлах гэмт хэрэг, автотээврийн хэрэгсэл хулгайлах гэмт хэрэг, дээрэмдэх гэмт хэрэг, хөрөнгө завших гэмт хэрэг, алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал завших гэмт хэрэг, автотээврийн хэрэгслийг зөвшөөрөлгүй авч явах гэмт хэрэг, нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, соёлын өвийн эсрэг гэмт хэргүүд 25,0-100,0 хувиар тус тус буурсан, хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг урьд оны мөн үетэй харьцуулахад ижил түвшинд байна.

Тус аймгийн хэмжээнд **гэмт хэргийн илрүүлэлт 43,4 хувь** байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад **3,5 хувиар өссөн**. Улсын дундаж 26,7 хувьтай гарсан ба Улсын дунджаас **16,7 хувиар өссөн** дүнтэй гарсан байна.

Гэмт хэргийн улмаас 371 иргэн хохирч, үүнээс 47 хүн нас барж, 117 хүн гэмтсэн. Үүнийг өмнөх онтой харьцуулахад нас барсан хүн 33 нэгжээр буюу 70,2 хувиар, гэмтсэн хүн 40 нэгжээр буюу 34,2 хувиар тус тус өссөн байна.

Гэмт хэргийн улмаас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад 2 тэрбум 276 сая 300 мянган төгрөгийн эдийн хохирол учирснаас 784 сая 300 мянган төгрөгийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлснээр хохирол нөхөн төлөлтийн хувь 34,5 хувьтай байна. Хохирол нөхөн төлөлтийн хувийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14,5 хувиар өссөн байна.

Тус цагдаагийн газарт нийт 22744 захиргааны зөрчил бүртгэгдэн өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7463 нэгжээр буюу 32,8 хувиар өссөн байна. Үүнээс:

- 204 иргэнийг баривчилж,
- 238 иргэнийг торгож, эрх хасах шийтгэл ногдуулсан.

2019 оны эхний 06 дугаар сард Төв аймгийн хэмжээнд баривчлагдсан хүн 2,0 хувиар, торгож, эрх хассан 61,3 хувиар, захиргааны нийт зөрчил 32,8 хувиар тус тус өссөн байна.

**Жижүүрийн шуурхай албаны чиглэлээр:** Тайлангийн хугацаанд жижүүрийн шуурхай албанд гэмт хэргийн шинжтэй 272, зөрчлийн шинжтэй 609, эрэн сурвалжлалт, зарлан мэдээллийн 53, нийт 934 мэдээ мэдээлэл хүлээн авч, иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн гомдол, мэдээллийг нэн даруй нэгдсэн сан болон дуудлага мэдээллийн санд бүртгэж, хариуцсан алба хаагч албан тушаалтнаар шалгуулан хоногийн нөхцөл байдлын мэдээнд тусган жижүүрийн бүрэлдэхүүн, хэсгийн байцаагч, хэсгийн төлөөлөгч, эргүүлийн цагдаа болон хөдөлгөөнт эргүүлийг явуулан шалгуулж, хяналт тавьж байна.

Эрүүлжүүлэх, баривчлах, саатуулах байр, нийтийн хэв журам сахиулах эргүүл, замын цагдаагийн эргүүл, шүүхийн байр, өндөр довын постонд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагч, хэсгийн байцаагч нартай 2 цаг тутамд утсаар болон станцаар, 26 сумдын хэсгийн төлөөлөгч, цагдаа нартай өдөрт 3 удаа утсаар холбогдож нөхцөл байдлын талаар мэдээг авч, үйл ажиллагаа, цаг ашиглалтад нь хяналт тавин удирдлагаар ханган ажиллаж байна.

Цагдаагийн ерөнхий газрын Шуурхай удирдлагын штаб, Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн ерөнхий зохицуулагч нарт тогтсон цаг хугацаанд холбогдож мэдээлэл солилцон үүрэг чиглэл авч, хоногийн нөхцөл байдлын мэдээг 05:00 цагт баталгаажуулж байна.

Зуунмод сумын төвд байрлах хяналтын камер, цагдаагийн газрын албан тасалгааны болон гадна 22 хяналтын камер, нийт 5 дэлгэцэнд 24 цагаар хяналт тавьж байна.

**Холбоо мэдээллийн чиглэлээр:** Цагдаагийн газрын хэт богино долгионы радио гар станц, суурин станцын хэвийн ажиллагааг хангаж, дотоод сүлжээ болон интернет сүлжээнд өдөр тутам хяналт тавьж хэвийн ажиллагааг хангаж байна. Конторын 10 алба хаагчийн компьютерыг форматалж, шаардлагатай программ хангамжийг суулгаж 1 компьютерыг сэлбэсэн. Эрүүлжүүлэх саатуулах байрны теле хяналтын камерыг засварлаж, цахим сангийн гарын авлага 33 хувийг бэлтгэж алба хаагчдад тараасан. Цагдаагийн газрын суурин телефон утас, Зуунмод суманд ашиглагдаж байгаа теле хяналтын камерын хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна.

**Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр:**

**Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр:** Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн дагуу чиглэл 1,2,3-ын хамгаалалтад 13 удаа ажиллахад 119 алба хаагч, 35 тээврийн хэрэгсэл, 585 тусгай хэрэгсэл, 53 холбооны хэрэгсэлтэй 461 хүн/цагийн үүрэг үүрэг гүйцэтгэж 2150 гаруй иргэдийн аюулгүй байдлыг хангаж ажилласан.

Олон нийтийг хамарсан 11 удаагийн 121 цаг үргэлжилсэн арга хэмжээний хамгаалалтад 152 алба хаагч, 43 тээврийн хэрэгсэл, 725 тусгай хэрэгсэл, 63 станцтай 1420 хүн/цагийн үүрэг гүйцэтгэж 11330 орчим иргэний аюулгүй байдлыг хангасан.

Төв аймгийн нутаг дэвсгэрт зохион байгуулагдсан 3 удаа 173 цаг үргэлжилсэн жагсаал цуглааны хамгаалалтад 65 алба хаагч, 7 тээврийн хэрэгсэл, 325 тусгай хэрэгсэл, 19 станцтай 153 хүн/цагийн үүрэг гүйцэтгэж 70 иргэний аюулгүй байдлыг хангаж ажилласан.

Төв аймгийн Сэргэлэн сумын 4-р багийн нутаг Олон овоот гэх газарт Улаанбаатар хот Баянгол дүүрэг 5-р хороо 113-р байр 14 тоотод оршин суух хаягтай Дугардоржийн Галбаатарын эзэмшлийн 16 тооны гахайд Африкийн гахайн мялзан өвчний шинж илэрсэн 19-315 дугаартай дүгнэлтийн дагуу Төв аймгийн Засаг даргын 2019 оны А/17 тоот “Хорио цээрийн дэглэм тогтоох тухай” захирамжаар Сэргэлэн сумын постод 1, Зуунмод сумын постод 1 алба хаагч 24 цагаар 720 хүн/цагийн үүрэг гүйцэтгэсэн.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2019 оны 01/483 дугаартай албан бичгийн дагуу тус Цагдаагийн газрын алба хаагч нарт газар хөдлөлт, гамшгийн нөхцөл байдал үүссэн үед мэргэжлийн анги ажиллах зарлан мэдээллийн дохиогоор нэгдсэн сургалт зохион байгуулсан.

Тэсэрч дэлбэрэх бодис хадгаладаг, үйлдвэрлэдэг, хэрэглэдэг аж ахуйн нэгжүүдэд Төв аймгийн тагнуулын хэлтэс, Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газар хамтарсан шалгалт зохион байгуулж тэсэрч дэлбэрэх бодис үйлдвэрлэдэг, хэрэглэдэг, ашигладаг 8 аж ахуйн нэгж, тухайн байгууллагын аюулгүй байдлыг хангаж байгаа 6 гэрээт харуул хамгаалалтын албанд шалгалт хийж 6 албан мэдэгдэл өгч, хууль бусаар хийн буу эзэмшиж байсан 2 хамгаалалтын албаны галт зэвсгийг хураасан.

Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төв аймгийн Засаг даргын орлогч, Нийтийн хэв журам хамгаалах олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны даргын үүрэг ажлыг чиглэлийг хэрэгжүүлэхээр Цагдаагийн газрын хэлтэс, тасаг, хэсгийн дарга, хэсгийн төлөөлөгч, хэсгийн байцаагч нарт хугацаатай үүрэг ажлын чиглэл хүргүүлж хурдан морины ажил хийж байсан 4 удаагийн арга хэмжээнд 65 иргэнд холбогдох тушаал шийдвэрийг танилцуулж Төв аймгийн хэмжээнд 1350 иргэнд холбогдох тушаалыг нэг бүрчлэн танилцуулж гарын үсэг зуруулж авсан.

Төв аймгийн онцгой комиссоос объектын болон ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ирүүлсэн үүрэг, ажлын чиглэлийг 4 байгууллага, 27 сумдын Засаг дарга нарт хүргүүлж, сумдын Засаг дарга нарын захирамжаар 2019 оны 3 сарын 20-ны өдрөөс 6 сарын 20-ны хооронд ойн бүсэд зорчих хөдөлгөөнийг хориглох захирамж гаргуулан, Төв аймгийн онцгой комиссын 02 тоот даалгавар, Нийтийн хэв журам хамгаалах олон нийтийн аюулгүй байдлын хангах албаны даргын үүрэг ажлын чиглэлийн дагуу 5 бүлэг бүхий төлөвлөгөө гаргаж, зааварчилгааны хамт хэлтэс, тасаг, хэсгийн дарга, хэсгийн төлөөлөгч, хэсгийн байцаагч, зохицуулагч нарт хүргүүлж, хэрэгжилтийг хангах чиглэлээр 5 суманд 17 цэгт хяналтын постыг 1 сарын хугацаатай ажиллуулсан.

**Нийтийн хэв журам хамгаалах эргүүл:** Нийтийн хэв журам хамгаалах эргүүд 7 чиглэлд 4 алба хаагч 2007 хүн/цагийн эргүүлийн үүрэг гүйцэтгэж, ахуйн хүрээний 211 дуудлага мэдээлэл хүлээн авч, 95 иргэнийг саатуулах байранд, 169 иргэнийг ар гэр асран хамгаалагчид нь хүлээлгэн өгч, төрийн болон төрийн бус байгууллагын 590 харуул манаа, 654 хүнсний дэлгүүр, 258 баар, караоке, 149 шатахуун түгээх цэг салбар, 271 тээврийн хэрэгсэл, 10 мотоцикл шалгаж, 90 айл өрхөөр орж ажилласан байна.

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн дагуу 55 удаа 110 хүн/цаг, 1 удаагийн хэргийн газрын хамгаалалтад ажиллаж нэгдсэн санд 118 удаа хандалт хийж, Цагдаагийн газраас зохион байгуулсан 43 удаагийн сургалтад хамрагдаж, зөрчил гаргасан 16 иргэнийг 200,000 төгрөгөөр торгох шийтгэл оногдуулсан.

Сумдын цагдаа нар: 26 суманд 18 цагдаа 45 чиглэлд 13017 цагийн үүрэг гүйцэтгэж хэргийн газрын хамгаалалтад 72 удаа ажиллаж, эргүүл хамгаалалтад 998 удаа 3917 хүн/цаг үүрэг гүйцэтгэж, 6 хэрэг илрүүлж, ASAP санд гэмт хэрэгт сэрдэгдсэн, шүүхээс даалгасан 14 иргэн олж тогтоон, эрэн сурвалжлалт зогсоосон, гэмт хэрэг зөрчлийн шинжтэй 441 дуудлага мэдээлэл хүлээн авч, биеэ авч явах чадваргүй согтуу явсан 315 иргэнийг ар гэр асран хамгаалагчид, эрүүлжүүлэх, саатуулах байранд 63 иргэнийг хүлээлгэн өгч, цагдаагийн ерөнхий газрын нэгдсэн санд 607 удаа хандаж, зөрчил гаргасан 771 иргэнийг 29.065.500 төгрөгөөр торгох шийтгэл оногдуулсан. Албан хэрэг хөтлөлтөөр хариуцсан суманд бүртгэгдэж байгаа 660 бичиг баримтад хөтлөлт хийж, гэмт хэргийн шинжтэй 61 үйлдэлд илтгэх хуудас бичиж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 33 арга хэмжээ зохион байгуулж, хутга, мөс зодооны хэрэгсэл 2 хураан, 8 гэмт хэрэг таслан зогсоож ажилласан.

Зуунмод сумын 6-н багт хэсгийн байцаагч нар үүрэг гүйцэтгэж гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 43 хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулж, 8 аж ахуйн нэгж байгууллагыг гадаад, дотоод камержуулж, гэр бүлийн хүчирхийллийн 57 дуудлагад явж, 92 хүчирхийлэл үйлдсэн этгээдийг эрүүлжүүлэх, саатуулах байранд хүлээлгэн өгч, 27 иргэнийг албадан саатуулж, 81 хүчирхийлэл үйлдсэн этгээдэд хяналт тавьж, 52 иргэнийг шүүхээр баривчлуулж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Төв аймгийн телевиз, цахим хуудсаар 15 удаагийн урьдчилан сэргийлэх нэвтрүүлэг явуулж, 111 аж ахуйн нэгж байгууллагад мэдэгдэл өгч, хараа хяналтгүй явсан 6 хүүхдийг ар гэр асран хамгаалагчид нь хүлээлгэн өгч, Цагдаагийн ерөнхий газрын Патрол санд 418 мэдээллийг оруулж, эргүүл хамгаалалтад 354 удаа ажилласан.

Зөрчлийн хэрэг бүртгэлтийн чиглэлээр 236 гомдол мэдээлэл хүлээн авч, 86 гомдол мэдээлэлд зөрчлийн хэрэг үүсгэж, 83 гомдол мэдээллийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзах саналтай аймгийн прокурорын газарт шилжүүлж, 8 гомдол мэдээллийг харъяаллын дагуу шилжүүлж, хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр 2 материалыг хааж, захиргааны журмаар хураагдсан 126 эд зүйлийг нэгдсэн санд шивэлт хийж хураагдсан эд зүйлийг устгах комисст шилжүүлж, зөрчил гаргасан 116 хүнийг 9.950.000 төгрөгөөр торгох шийтгэл оногдуулсан байна.

Архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр: Аймгийн хэмжээнд согтууруулах ундааны зүйл худалдан борлуулдаг бөөний төв 1, хүнсний дэлгүүр 88, ресторан зоогийн газар 2, караоке 4-д хяналт тавьж, зохих зөвшөөрлгүй худалдаа хийсэн 2 аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсоохоор холбогдох байгууллагад шилжүүлж, хяналт шалгалтын чиглэлээр ерөнхий 40, тусгай 8 арга хэмжээг нутгийн захиргааны 10, мэргэжлийн хяналтын 3, бусад 1 байгууллагатай хамтран зохион байгуулж, нийт 222 хүн, 54 хуулийн этгээд шалгаж, 3 зөрчил илрүүлж 3 иргэнийг 3500,000 төгрөгөөр торгох шийтгэл оногдуулж спирт 2 литр, 25 литр архи, 16 литр пиво хураан авч сумдын хураагдсан эд зүйлийг устгах орон тооны бус комисст шилжүүлсэн. Илэрсэн зөрчлийг арилгуулахаар 49 шаардлага хүргүүлж 16 шаардлагын хариуг хугацаанд нь авч, одоо хугацаа болоогүй 27 шаардлага мэдэгдэл байна. Архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр сургалтыг Засаг даргын тамгын газартай 13, холбогдох мэргэжлийн байгууллагатай 1, эрүүл мэндийн байгууллагатай 6, баг хороотой 9, төрийн бус

байгууллагатай 1, бусад 1 байгууллагатай хамтран зохион байгуулж 12020 иргэийг хамруулж 996 санамж сэргэмжлүүлэг тарааж, хэвлэл мэдээллийг хэрэгслээр 50 удаагийн сэргэмжлүүлэг мэдээг иргэд, олон нийтэд хүргээд байна.

**Тамхины хяналтын чиглэлээр:** Ерөнхий хяналт шалгалт 61, тусгай 18 арга хэмжээ зохион байгуулж 98 иргэн 37 хуулийн этгээд шалгаж 4 зөрчил илрүүлж, 4 иргэнийг 170.000 төгрөгөөр торгох шийтгэл оногдуулж, 19 хайрцаг, 6 ширхэг тамхи хураан авч сумдын хураагдсан эд зүйлийг устгах орон тооны бус комисст шижлүүлж, тамхины хор хөнөөлийн чиглэлээр 44 удаагийн сургалтыг сумдын Засаг даргын тамгын газартай 18, холбогдох мэргэжлийн байгууллагатай 8, эрүүл мэндийн байгууллагатай 6, баг хороотой 8, төрийн болон төрийн бус байгууллагатай 2 удаа зохион байгуулж, 679 иргэнийг хамруулж 583 санамж сэргэмжлүүлэг тарааж, хэвлэл мэдээллийн байгууллага цахим хуудсанд 30 удаагийн сэргэмжлүүлэг мэдээлэл байршуулж иргэд олон нийтэд хүргэсэн.

**Эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байрны чиглэлээр:** Гудамж талбай, олон нийтийн газар болон гэр орон, ахуйн хүрээндээ архи дан согтуурч бусдын амгалан тайван байдлыг алдагдуулж, жижгээр танхайрсан, согтуугаар тээврийн хэрэгслэл жолоодсон, өөрийгөө удирдан биеэ авч явах чадваргүй болтлоо согтсон, шүүхээр баривчлагдсан, албадан саатуулагдсан нийт 711 иргэнийг эрүүлжүүлэх саатуулах байранд хүлээн авснаас эрүүлжүүлэгдсэн 354 иргэн, албадан саатуулсан 88, шүүхээр баривчлагдсан 269 иргэнийг /код/ журмын дагуу биед болон эрүүл мэндийн үзлэг хийж хүлээн авсан.

Саатуулах байрны эмч нар саатуулах байранд баривчлах байрны үйл ажиллагааны явцад 21 иргэнд эмнэлгийн анхны тусламжийг үзүүлж, ар гэр, асран хамгаалагчид нь 70 иргэнийг хүлээлгэн өгч ажилласан байна.

Эрүүлжүүлэгдсэн 354 иргэдээс төлбөр болох 1,469,100 төгрөг, хугацаа дууссан 257 хүмүүжигчээс төлбөрийн чадвартай 224 иргэний төлбөр 6,165,350, төлбөрийн чадваргүй 33 иргэнийг багийн Засаг даргын тодорхойлолтоор хааж 7,634,450 төгрөгийг Төрийн сангийн дансанд тушааж, төлбөр төлөлт 100 хувьтай байна.

Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс 7-30 хоногийн хугацаагаар баривчлагдсан давхардсан тоогоор 1232 иргэнд “Зөрчлийн тухай хууль”, “Гэр бүлийн хүчирхийллэлтэй тэмцэх тухай хууль”, “Архи тамхины хор хөнөөл” сэдэвт сургалтыг 61 удаа 122 цаг зохион байгуулжээ.

**Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр:** Шүүхийн хамгаалалтын цагдаа нар шүүх хурлын 1,2,3-р танхимуудад 721 оролцогчтой Эрүүгийн хэргийн 805, Иргэний хэргийн 477, Захиргааны 48, Хянан магадлангийн 18 нийт 1348 шүүх хуралдаанд журам сахиулж ажилласан. Шүүх хуралдаан эхлэхээс 30 минутын өмнө шүүх хурлын танхимыг шалган тэмдэглэл үйлдэж, нарийн бичигт хүлээлгэн өгч, шүүх хурал даргалагчаас тогтоосон зохих журмын дагуу шүүх хуралдааны журам сахиулж, гэмт хэрэг, ноцтой зөрчил гарахаас урьдчилан сэргийлж ажилласан ба тайлангийн хугацаанд ямар нэгэн зөрчил гараагүй байна.

**Нүүдэлж ажиллах үеийн шүүх хуралдааны хамгаалалтын талаар:** ШШГЕГ-ын харьяа хорих 415, 417-р ангид хянан магадлангийн нийт 75 оролцогчтой эрүүгийн 14 шүүх хуралдаанд журам сахиулж шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангаж, шүүхийн байранд шүүгчийн туслах, нарийн бичиг, бусад ажилчидтай уулзахаар ирсэн нийт

5306 иргэний бичиг баримтыг шалгаж, дотоод сүлжээгээр зөвшөөрөл авч, зохих журмын дагуу шалган нэвтрүүлсэн.

**Эрэн сурвалжлалтын чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын талаар:** Төв аймаг дахь шүүхээс эрэн сурвалжлах 13 шүүгчийн шийдвэр хүлээн авч, шүүгчийн шийдвэрүүдийг бүртгэл хөтлөн хариуцсан нутаг дэвсгэрийн хэсгийн төлөөлөгч, хэсгийн байцаагч нарт хүргэж, хугацаа зааж ажиллаж байна. Эрэн сурвалжлах шүүгчийн 8 шийдвэрээр 8 иргэний оршин суугаа хаягийг тогтоож иргэний нэхэмжлэгч болон шүүхэд албан бичгээр хариу хүргүүлж ажилласан. Одоо биелэгдээгүй шүүгчийн шийдвэр 18 байна. Төв аймаг дахь Сум дундын Эрүү, Иргэн, Захиргааны хэргийн шүүхээс хариуцагч, гэрч, хохирогч, шүүгдэгч нарыг албадан ирүүлэх 37 шүүгчийн захирамж, тогтоол хүлээн авч, бүртгэл хөтлөн, хариуцсан алба хаагч нарыг томилон тэмдэглэл хөтөлж, албадан ирүүлэх 35 шүүгчийн захирамж, тогтоолоор 41 иргэнийг албадан ирүүлж хүлээлгэн өгсөн.

**Хуяглан хүргэлтийн чиглэлээр:** Хуяглан хүргэх төлөвлөгөө, томилгооны дагуу Цагдаагийн газрын жижүүрийн тээврийн хэрэгслээр Төв аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Цагдан хорих байрнаас 190 шүүгдэгчийг хүлээн авч биед нь үзлэг хийж, тэмдэглэл үйлдэж, шүүхэд хуяглан хүргэж, шүүх хуралдаанд оролцуулан буцааж, Төв аймаг дахь Шүүхээс 212 шүүгдэгч, яллагдагчийг Төв аймаг дахь Цагдан хорих байранд хуяглан хүргэж ерөнхий жижүүрт нь хүлээлгэн өгч ажилласан.

### **Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр:**

Төв аймгийн Цагдаагийн газарт 2019 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 360 гэмт хэрэг бүртгэгдэж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 90 нэгжээр буюу 25,0 хувиар, зөрчил 22744 бүртгэгдэж 7463 нэгжээр буюу 32,8 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Гэмт хэргийн илрүүлэлт 37,3 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 5,7 хувиар өссөн байна.

**Шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах чиглэлээр хийсэн ажил:** Нийт бүртгэгдсэн гэмт хэрэгт хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 11,2 хувь, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 23,8 хувь, үүнээс мал хулгайлах гэмт хэрэг 65,5 хувь, хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 52,3 хувиар тус тус өсөж, гэр бүлийн хүчирхийлэл 9,1 хувь, насанд хүрээгүй хүмүүсээс үйлдэгдсэн гэмт хэрэг 42,8 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Дээрх гэмт хэргүүдийн шалтгаан нөхцөлийг судлан үзэхэд архидан согтуурсан, малчид малаа хариулгагүй орхидог, махны үнэ өсөж амар хялбар аргаар мөнгө олох зорилгоор бусдын малыг бүлэглэн хулгайлах, байгалийн гамшиг үер, улсын чанартай Улаанбаатар-Налайх чиглэлийн авто замын засвар эхлэн хөдөлгөөний нягтрал ихсэж байгаатай холбоотой зам тээврийн гэмт хэрэг, зөрчил өссөн байна.

Тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлийг бууруулах зорилгоор Цагдаагийн ерөнхий газраас улсын хэмжээнд зохион байгуулсан “Сар шинэ”, “Нуугдмал”, “Нэг хором”, “Байгалиа хамгаалъя”, “Залилах”, “Зөв тусгал”, “Тээврийн хэрэгслийн гэрэлтүүлэх хэрэгсэл”, “Хурд”, “Тэмдэг, тэмдэглэлийн бүрэн бүтэн байдал”, “Мотоцикль”, “Орон нутгийн зам-хөдөлгөөн соёл 2019”, “Бяцхан зорчигч”, “Яараад яахав дээ” зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ, аян, Орон нутагт үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдлын онцлогт тохируулан “Судалгаа хяналт”, “АСАР сан”, “Шатахуун түгээх”, “Тулгалт”, “Мал”, “Баян”, “Сургалт сурталчилгаа”, “Тусгай дуут”, “Гэрэл дохио”, “Сургалт”, “Ой хээрийн түймэрээс урьдчилан сэргийлье”,

“Архидалтгүй-Зуунмод”, “Цахим” хэсэгчилсэн арга хэмжээг хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулан ажиллаж байна.

Олон нийтийн эргүүлээр ажиллуулах тухай аймгийн Засаг даргын /А/30 тоот/ захирамж гаргуулан төрийн болон хувийн хэвшлийн 50 аж ахуй нэгж байгууллагын 351 алба хаагчийг хамруулан нийтийн эргүүлийг ажиллуулсан.

“Хүүхэд хамгаалагч” төслийн хүрээнд тус цагдаагийн газраас өндөр насны тэтгэвэрт гарсан 2 ахмад ажилтныг “Хүүхэд хамгаалагч”-аар томилуулан насанд хүрээгүй хүмүүсийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр эргүүлийн үүрэг гүйцэтгүүлж байна.

Тус газрын сумдын хэсгийн төлөөлөгч, 6 багийн хэсгийн байцаагч нийт 36 алба хаагч аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, хууль хяналтын байгуулагуудтай хамтран зохион байгуулсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх нь”, малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Сэргэлэн, Лүн, Батсүмбэр, Баян-Өнжүүл, Алтанбулаг, Баяндэлгэр, Өндөрширээт зэрэг сумдад “Малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, малчдын оролцоо” сэдэвт малчдын зөвлөгөөнд хамрагдсан.

Сургалт, сурталчилгааны талаар хийсэн ажил: Нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ, аяны хүрээнд иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилгоор Эрүүгийн хуулийн хулгайлах гэмт хэрэг, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн тухай ойлголт, Зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, Зан үйл өөрчлөх, Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга, Өрхийн тэргүүний манлайлал зэрэг сэдвээр 199 удаагийн сургалт сурталчилгаа, 31 удаагийн уулзалт, хэлэлцүүлэг ярилцлага, 17 өдөрлөг, 7 уралдаан тэмцээн зохион байгуулан 33617 иргэн хамрагдсан байна.

Тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлийг бууруулах зорилгоор Цагдаагийн газраас улсын хэмжээнд зохион байгуулагдсан “Сар шинэ”, “Нуугдмал”, “Нэг хором”, “Байгалиа хамгаалъя”, “Залилах”, “Зөв тусгал”, “Тээврийн хэрэгслийн гэрэлтүүлэх хэрэгсэл”, “Хурд”, “Тэмдэг, тэмдэглэлийн бүрэн бүтэн байдал”, “Мотоцикль”, “Орон нутгийн зам- хөдөлгөөн соёл 2019”, “Бяцхан зорчигч”, “Яараад яахав дээ” зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ, аян, Орон нутагт үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдлын онцлогт тохируулан “Судалгаа хяналт”, “АСАР” сан” “Шатахуун түгээх”, “Тулгалт”, “Мал”, “Баян”, “Сургалт сурталчилгаа”, “Тусгай дуут, гэрэл дохио”, “Сургалт”, “Ой хээрийн түймэрээс урьдчилан сэргийлье”, “Тандалт”, “Архидалтгүй-Зуунмод”, “Камерын хяналт”, “Шийдвэрлэлт 2019” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулан арга хэмжээний хүрээнд 76 төрлийн гарын авлага, зурагт хуудас, 32 төрлийн санамж сэрэмжлүүлэг, 71 төрлийн 21580 ширхэг тараах материалыг гудамж талбай, олон нийтийн газар, төрийн болон төрийн бус байгууллагын мэдээллийн самбарт байрлуулсан байна.

Хэвлэл мэдээллийн байгууллага, нийтийн цахим сүлжээнд мэдээ, мэдээлэл түгээх, үхүүлгэ, нөлөөллийн арга хэмжээ авсан байдал: Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтсийн page, Нийслэлийн Цагдаагийн газрын page хуудсанд тавигдсан “Хулгайн гэмт хэрэгээс урьдчилан сэргийлье” аяны хүрээнд “Хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлье”, “Малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлье”, “Автомашин хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлье”, “Хулгайчид боломж бүү олго-та сэргийлж чадна”, “Хулгайчаас салцгаая”, “Мал хулгайлах гэмт хэргээс

урьдчилан сэргийлье”, Хулгайн гэмт хэрэгтэй тэмцэхэд техник, технологийн дэвшлийг ашиглах нь “Халуун сэдэв”, нэвтрүүлэг, “Хулгайгаас сэргийлье”, “Халаасны хулгай”, “-С Градус” “Нэг хором” аян, “Сэргийлэгч охины санамж”, “сэргийлэгч хүүгийн санамж”, “Хар тамхи”, “Зөв тусгал” подкаст, “Яараад яахав дээ” нэвтрүүлэг, видео, шторк, постерийг цахим хуудсанд 240 мэдээллийг хандалт ихтэй давхардсан тоогоор 54 группэд share хийж байршуулан 17,502,970 иргэдэд хүргэсэн.

Осол, гэмтэл, болзошгүй эрсдэл, цаг агаарын аюулт үзэгдэл гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Төв аймгийн Эрүүл мэндийн газар, Онцгой байдал, Мэргэжлийн хяналтын газар, Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран мэдээ, мэдээллийг цаг тухай бүрт нь солилцон, нөхцөл байдлыг үнэлж Төв аймгийн Төв, TBS телевизэд арга хэмжээний талаар сурталчилж, ард иргэдэд анхааруулга, сэрэмжлүүлэг мэдээлэл 115 удаа видео шторк 8 төрлийг /“Халаасны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлье”, “Орон байрны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлье”, “Камерын хяналт”, “Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх”, “Нэг хором” аян, “Зөв тусгал”, “Бяцхан зорчигч”, “Архидалтгүй зуунмод, Амар тайван Зуунмод”/ нэгдсэн арга хэмжээний үеэр өдөр бүр 3 удаагийн давтамжтай нэвтрүүлэн ажилласан.

Малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Төв, TBS телевизтэй хамтран иргэдэд анхааруулга нэвтрүүлэг 5 бэлтгэн, 5422 гар утастай хэрэглэгчдэд “Мал хулгайлах гэмт хэргийн гаралт нэмэгддэг тул малчид та бүхэн бод малыг байнгын хариулга, маллагаатай байлгаж сонор сэрэмжтэй байхыг анхааруулж байна” багц мессэжийг иргэдийн гар утсанд түгээж, дээрх сэрэмжлүүлгийг Төв аймгийн урсдаг зарлалд байршуулсан.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийг иргэдэд мэдээлэх, сурталчлах, хууль эрх зүйн зөвлөгөө өгөх, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах зорилгоор Монголын Хуульчдын холбооноос жил бүр зохион байгуулдаг “**Про боно**” сэдэвт Нээлттэй өдөрлөг арга хэмжээг зохион байгуулсан. Мөн “Байгалиа хамгаалъя”, “Залилан мэхлэх” гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Төв аймгийн нэг цэгийн үйлчилгээний газар болон Андууд худалдааны төвд, “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг”, “Ой хээрийн түймэр”-ээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тус аймгийн Дулааны эрчим хүчний газарт “Нээлттэй өдөрлөг” арга хэмжээг зохион байгуулж, цагдаагийн байгууллагын ажил үйлчилгээний талаар 30 иргэнээс санал асуулгын хуудсаар болон амаар гаргасан санал, хүсэлтүүдийг хүлээн авч, 8 иргэнийн гаргасан санал хүсэлтийг газар дээр нь хариу өгч, 885 гарын авлага, санамж сэрэмжлүүлэг тарааж ажилласан.

### **Хөдөлгөөний өюүлгүй байдлыг хангах чиглэлээр:**

Тайлант хугацаанд замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор гудамж замын хяналт шалгалтаар 128,066 тээврийн хэрэгсэл шалгаж 28,469 зөрчил илрүүлж, МУ-ын Зөрчлийн тухай хуулийн 14 дугаар зүйлийн 7.3.1, 7.5 дахь заалтуудыг зөрчиж согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 347 жолоочийг илрүүлэн тээврийн хэрэгслийг саатуулж ажилласан байна.

***Захиргааны зөрчлийн шийдвэрлэлтийн талаар:*** Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож хөдөлгөөнд оролцсон 273 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жилээр хасаж, хуульд заасны дагуу 400 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй

үедээ согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож хөдөлгөөнд оролцсон 74 иргэнийг Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэврээр баривчилуулж, ЦЕГ-ын туслах тоо бүртгэлийн санд мэдээллийг бүртгэжээ.

Зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, холбогдох хууль тогтоомж зөрчсөн нийт 28,205 жолоочийг 859,140,500 төгрөгөөр торгож, Зөрчлийн тухай хуулийн 14.7.32 дугаар заалтыг зөрчин зөрчил гаргасан нийт 14 жолоочийн эрхийг 6 сарын хугацаатайгаар хасч, 50 нэгжээр торгосон, зөрчил гаргасан 194 жолоочийн тээврийн хэрэгслийг түр саатуулж ажилласан байна.

Цагдаагийн газрын жижүүрийн шуурхай удирдлагын төвийн 102 дугаарын утсанд иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн зам тээврийн хэрэг, ослын 218 гомдол, мэдээлэл, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код-202-ын дагуу хүлээн авснаас зам тээврийн гэмт хэргийн шинжтэй 77, эд материалын хохиролтой 100 мэдээлэлд тус тус хэрэг, ослын газрын үзлэг хэмжилт хийж ажилласан байна.

*Төв аймагт 2019 оны эхний хагас жилд бүртгэгдсэн зам тээврийн осол, хэрэг болон ЗЦТ-аас илрүүлсэн зөрчлийг өмнөх оны мөн үетэй харьцуулсан үзүүлэлт:*

№	Харь- цуулсан хугацаа			Осол, хэргийн судалгаа			Захиргааны зөрчлийн судалгаа			
		Нийт осол	хэрэг	Нас барсан	Гэмтсэн	Илрүүлсэн зөрчил	Торгосон		Согтуугаар түх жолоодсон	
							хүн	төг	Эрх хасагдсан	14.7.5
1	2018 оны эхний хагас жил	138	19	11	116	19,187	17,565	591,345, 250	244	63
2	2019 оны эхний хагас жил	181	65	26	81	28,469	28,205	859,140, 500	273	74
3	Нэгж	+43	+46	+15	-35	+9282	+10,640	+267,79 5,250	+29	+11
4	Хувь	23,7% офф	70,7% өссөн	57,6% офф	- 30,1 % буур сан	+32,6% өссөн	+37,7% өссөн	+31,1% өссөн	+10,6% өссөн	+14,8 % өссөн

**Урьдчилан сэргийлэх чиглэлээр:** Иргэдэд Зөрчлийн тухай хууль тогтоомжийг сурталчлан таниулах чиглэлээр Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд [tuv.police.gov.mn](http://tuv.police.gov.mn). “Төв аймгийн Цагдаагийн газар”, “Орон нутгийн замын цагдаа” гэсэн facebook хаягаараа дамжуулан зам тээврийн осол, хэргээс урьдчилан

сэргийлэх, замын зохион байгуулалтын чиглэлээр хийсэн ажил, цаг агаарын нөхцөл байдал, хариуцсан нутаг дэвсгэрт зохион байгуулсан арга хэмжээний талаар 104 мэдээ, мэдээлэл оруулж сэрэмжлүүлсэн ба зурагт хуудас 1029 ширхэг, санамж 1414 ширхэг, гарын авлага 145 ширхэг хэвлүүлж жолооч, зорчигч нарт тараажээ.

**Замын зохион байгуулалтын чиглэлээр:** Тайлангийн хугацаанд аймгийн хэмжээнд орших хатуу хучилттай замын арчлалтыг сайжруулах талаар анхаарч зам засвар арчлалтын “Төв АЗЗА” ТӨХК, “Эрдэнэсант АЗЗА” ТӨХК Багануур АЗЗА ТӨХК, Налайх АЗЗА ТӨХК, Зуунмод сумын хот тохижуулах газар, Төв гэрэл зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж явган хүний зам, гудамж замын гэрэлтүүлэг, авто замын цас, мөстсөн хэсгийг тухай бүр арилгуулж хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулж ажилласан байна.

Төв аймгийн хэмжээнд замын нөхцөл байдал хүндэрсэн, зам эвдэрсэн үүссэн нөхцөл байдалтай холбогдуулж албан байгууллага аж ахуй нэгж, иргэнд нийт 19 албан мэдэгдэл хүргүүлж 16 мэдэгдлийн хариу авсан.

Төв аймаг Сэргэлэн сум Эрдэнэ уул 4-р баг Хустайн даваа гэх газар Улаанбаатар хотоос Мандалговь чиглэлийн авто замын 38-39 км-ын огцом эргэлттэй, үзэгдэх орчин хязгаарлагдсан хэсэгт “Эргэх чиг”-ийн 12 ш тэмдэг MNS 4597-2013 стандартын дагуу хийж байрлуулсан ба 150 м урт туузан ган хашлага, Замын тэнхлэгийн гэрэл ойлгогчтой 200 ш товруу тоноглол, улаан цэнхэр асдаг нарны гэрлээр 3 ш гэрэл зэргийг байрлуулсан.

Улаанбаатар Налайх чиглэлийн замыг хаах болсонтой холбогдуулан Төв аймаг Өндөрдов-Зуунмод-Налайх А-25 чиглэлийн замд шаардлагатай тэмдэг, тэмдэглэгээ тоноглолын судалгааг гаргаж холбогдох албадад хүргүүлсэн байна. Улаанбаатар-Мандалговь А0201 чиглэлийн замд Төв АЗЗА ТӨХК замын эвдрэлд 55м<sup>2</sup> хүйтэн нөхөөс, Улаанбаатар-Арвайхээр А0301 чиглэлийн замд Эрдэнэсант АЗЗА ТӨХК замын хажуу талын хогыг цэвэрлүүлсэн.

Зуунмод сумын төвийн гудамж замын гэрэлтүүлгийг сайжруулах, асахгүй байгаа гэрлүүдийг засварлан асааж хэвийн ажиллагаанд оруулах чиглэлээр эвдрэлтэй гэрлүүдийн тоо судалгааг гарган тухай бүр Аймгийн Засаг даргын тамгын газар, Төв шинэчлэл УҮГ-т хүргүүлэн шаардлага тавьж ажилласнаар Зуунмод сумын төвийн гудамж замын 2558 гэрлээс асахгүй байсан 7 гэрлийг засварлан асаалгаж гудамж замын гэрэлтүүлэг 100% хувьтай байна. Уулзвар гарцан дээр шинээр гэрэл дохио тавиагүй.

Одоогийн байдаар Зуунмод сумын Нэгдсэн эмнэлэгийн баруун 4 замын уулзвар, Соёлын төвийн уулзварын гэрэл дохио, Хуучин Музейн 3 замын уулзварын гэрэл дохио хэвийн ажиллаж байгаа. Замын зорчих хэсэгт ажил гүйцэтгэх зөвшөөрөл олгоогүй байна.

**Заамар сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн үйл ажиллагааны талаар:**

**Эрүүгийн цагдаагийн алба:** Тайлангийн хугацаанд 23 шилжүүлэх материалаар 86.180.000 төгрөгний хохиролтой, 33 холбогдогчтой, 23 гэмт хэрэг үйлдлийг илрүүлэн бусад байгууллагаас эрэн сурвалждагдаж байсан 6 гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээдийг олж тогтоон холбогдох байгууллагад хүлээлгэн өгсөн.

Мөрдөн байцаах хэсэг: Гэмт хэргийн шинжтэй 35 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 26-д хэрэг бүртгэлтийн болон мөрдөн байцаалтын хэрэг нээн, 8 гомдол мэдээллийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 1 гомдол мэдээллийг харъяаллын дагуу шилжүүлж, одоо гомдол мэдээллийн үлдэгдэлгүй, гомдол, мэдээллийн шийдвэрлэлт 100 хувьтай байна. Шийдвэрлэсэн нийт гомдол, мэдээллээс 33 буюу 97.1 хувийг 5 хоногт шийдвэрлэсэн.

Эхний хагас жилд нийт 86 холбогдогчтой 78 хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэг шалгаснаас 42 холбогдогчтой 36 хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлж, хэрэг бүртгэлтийн 21 хэргийг хааж 57 хэрэг буюу 80.1 хувийг шийдвэрлэж, 16 холбогдогчтой 21 хэргийн үлдэгдэлтэй, хугацаа сунгасан хэрэг 9 байна.

Гэмт хэргийн улмаас иргэд байгууллага, аж ахуйн нэгжид 130.2 сая төгрөгийн хохирол учирснаас хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд 84.2 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, 33.9 сая төгрөгийн хөрөнгө битүүмжлэн хамгаалсан ба хохирол нөхөн төлүүлэлт 64.6 хувьтай байна.

Шийдсэн хэргээс шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт санал хүргүүлсэн 36 хэрэгт гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар мөрдөгчийн мэдэгдэл бичиж, 21 мэдэгдэлийн хариуг авсан.

86 холбогдогчтой 71 хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэг шалгаснаас 42 холбогдогчтой 36 хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлж хэрэг бүртгэлтийн 21 хэргийг хааж, 57 хэрэг буюу 80.2 хувийг шийдвэрлэсэн байна.

Нийтийн хэв журам хамгаалах чиглэлээр: Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн дагуу чиглэл 1,2,3-ын 7 удаагийн хамгаалалтад 75 алба хаагч, 21 тээврийн хэрэгсэл, 365 тусгай хэрэгсэл, 38 холбооны хэрэгсэлтэй 347 хүн/цагийн үүрэг үүрэг гүйцэтгэсэн. Олон нийтийг хамарсан 4 удаагийн 27 цаг үргэлжилсэн арга хэмжээний хамгаалалтад 53 алба хаагч, 9 тээврийн хэрэгсэл, 250 тусгай хэрэгсэл, 26 станцтай 247 хүн/цагийн үүрэг гүйцэтгэж 2930 орчим иргэний аюулгүй байдлыг хангаж ажилласан байна.

Заамар сумын Хайлааст багийн төвд эргүүлийн цагдаа нар Цагдаагийн хэлтсийн даргын баталсан томилгооны дагуу 2 чиглэлд давхардсан тоогоор 244 алба хаагч 8 цагаар эргүүлийн үүрэг гүйцэтгэж, гудамж талбай олон нийтийн газар архи, согтууруулах ундааны зүйл ууж хэрэглэж биеэ авч явах чадваргүй явсан 280 иргэнийг ар гэр, асран хамгаалагчид нь хүлээлгэн өгч, зөрчил гаргасан болон дуудлагаар очсон үедээ 70 иргэнийг Цагдаагийн хэлтсийн жижүүрт хүлээлгэн өгч 6 цагаар түр саатуулах арга хэмжээ авч холбогдох алба хаагчдад шилжүүлэн өгсөн.

Хэсгийн алба хаагчдаас гэмт хэргийн шинжтэй мэдээлэл нийт 35 гэмт хэргийн талаарх мэдээллийг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код/-307-д заасны дагуу бичиж, холбогдох алба хаагчаар шалгуулахаар шилжүүлсэн байна.

Тус хэсгийн алба хаагчид хариуцсан нутаг дэвсгэрт замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр ажиллаж нийт 2684 тээврийн хэрэгсэл шалгаж, 315 зөрчил илрүүлж, зөрчилтэй явсан 590 жолоочийг 19,320,000 төгрөгөөр торгож ажилласан байна. Хэсгийн алба хаагчдаас зөрчлийн шинжтэй нийт 94 өргөдөл гомдол хүлээн авч шалгаснаас 3 гомдлыг татгалзах саналтайгаар, 2 гомдлыг харъяалын дагуу шилжүүлж, 14 гомдолд зөрчлийн хэрэг нээж, гомдлыг хялбаршуулсан журмаар шалгаж, зөрчил гаргасан 94 хүнийг 800,00 төгрөгөөр торгож арга хэмжээ авч, гэр

бүлийн хүчирхийлэл үйлдсэн 27 хүнийг эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр 7-30 хоногийн хугацаагаар баривчлуулжээ.

**Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр:** Төв аймгийн Цагдаагийн газрын Заамар сум дахь сум дундын цагдаагийн хэлтэст 2019 оны эхний хагас жилд 57 гэмт хэрэг бүртгэгдэж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10 нэгжээр буюу 17.5 хувиар өссөн, зөрчил 283 бүртгэгдэж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 53 нэгжээр буюу 18.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

**Шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах чиглэлээр хийсэн ажил:** Нийт гэмт хэргээс дийлэнхи бүртгэгддэг гэмт хэрэг Хулгайлах гэмт хэрэг үүнээс малын хулгайн гэмт хэрэг 33 бүртгэгдэж урьд оны мөн үетэй харьцуулахад 7 нэгжээр буюу 21 хувиар өссөн, Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгсэл ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 6 бүртгэгдэж урьд оны мөн үетэй харьцуулахад 3 нэгжээр буюу 50 хувиар өссөн байна. Хулгайлах гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судалж үзэхэд малчид малаа хариулгагүй орхисон, туслах малчнаар хүн авахдаа хувийн байдлыг нь судалж үздэггүй, махны үнэ өссөнтэй холбоотой амар хялбар аргаар мөнгө олох зорилгоор бусдын олон тооны малыг бүлэглэн хулгайлсан байна.

Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгсэл ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн талаар авч үзвэл архи дан согтуурсан, хол замд үүрэглэж ядарсан, анхаарал болгоомжгүй замын хөдөлгөөнд оролцсон, замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг дутуугаас болж ихэнх тохиолдолд замын тээврийн осол үйлдэгдэж байна.

**Сургалт, сурталчилгааны талаар хийсэн ажил:** Цагдаагийн хэлтсийн даргын баталсан төлөвлөгөөний дагуу Төв аймгийн Заамар, Баянхангай, Угтаалцайдам, Эрдэнэсант сумдад 2018 оны үйл ажиллагааны тайлан болон малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээ мэдээлэл хийж мөн сумдын хэсгийн төлөөлөгчид 2018 онд хийсэн ажлын тайлан болон 2019 онд урьдчилан сэргийлэх чиглэлээр ямар ажил арга хэмжээ зохион явуулах талаар иргэдтэй санал бодлоо солилцож уулзалт зөвлөгөөнийг зохион байгуулав.

Төв аймгийн Лүн, Өндөрширээт сумдад малчдын чуулга уулзалт болж тус Цагдаагийн хэлтсээс мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд малчдын оролцоог нэмэгдүүлэх, анхаарах асуудлын талаар мэдээлэл хийсэн байна.

Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд 65 мэдэгдэл хүргүүлэн үүнээс 56 мэдэгдлийн хариуг авч биечлэн газар дээр нь 9 мэдэгдлийг шалгаж хариу ирүүлээгүй 2 иргэнийг 200,000 төгрөгөөр торгож ажилласан байна.

### **Гурав: Дүгнэлт:**

Тус Цагдаагийн газар нь Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2019 онд дэвшүүлсэн зорилт, Цагдаагийн ерөнхий газрын даргын удирдах ажилтны сургалт, зөвлөгөөний үеэр өгсөн үүрэг, “Цагдаагийн ерөнхий газраас 2018 онд хяналтад авч, хэрэгжилтийг зохион байгуулсан бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж өгсөн зөвлөмж”, Монгол улсын Засгийн газрын 2017 оны “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 01 дүгээр албан даалгавар, Засгийн газрын

2018 оны “Төрийн алба хаагчийн сахилга хариуцлагыг сайжруулах тухай” 258 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Алба хаагчдын албанд хандах хандлага, сахилга, хариуцлагыг дээшлүүлэх ажлын хүрээнд цагдаагийн газрын даргаас алба хаагч нартай “Итгэлцлийн гэрээ” байгуулж, “Сахилга, хариуцлагыг дээшлүүлье”, “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын сахилга, ёс зүй, аюулгүй байдлыг сайжруулах, авлигын гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх” сэдвээр илтгэлийн уралдааныг 2 удаа, сахилгын зөвлөгөөнийг нэгдсэн байдлаар 3 удаа, хэсэгчилсэн байдлаар 2 удаа зохион байгуулж зөрчил гаргасан 25 алба хаагчид ажиллах урам зориг, итгэлийг сэргээсэн урмын үгтэй “Итгэл найдварын захидал”-ыг гардуулах, “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын ахмад, дунд, залуу үеийн залгамж холбоог хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд алдар гавъяатай ахмадуудыг урьж “Уламжлал ба шинэчлэл” уулзалт ярилцлагыг 3 удаа, “Эерэг хандлагыг төлөвшүүлье” 45 хоногийн аяныг зарлаж аяны хүрээнд алба хаагчдын дунд “Хамт олондоо талархъя”, “Шинэ санал санаачилгыг дэмжье”, “Тохилог ажлын байр” аян зэрэг олон талт ажил, арга хэмжээг зохион байгуулсан нь алба хаагчдад албаараа бахархах сэтгэл төрүүлж, урам зоригийг нэмэгдүүлсэн, хамт олны дунд эвсэг, тусархаг уур амьсгалыг бүрдүүлж багаар ажиллах чадварыг дээшлүүлсэн үр дүнтэй ажил, арга хэмжээнүүд болсон гэж дүгнэж байна.

Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх чиглэлээр цаг үеийн нөхцөл байдал, нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгаа, эргүүл хяналт шалгалтыг эрчимжүүлж нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулснаар 2019 оны эхний хагас жилийн байдлаар гэмт хэргийн улмаас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад 2 тэрбум 276 сая 300 мянган төгрөгийн эдийн хохирол учирснаас хохирол нөхөн төлөлтийн хувь 34,5 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14,5 хувиар өссөн, гэмт хэргийн илрүүлэлт 43,4 хувь байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3,5 хувиар өссөн, захиргааны зөрчлийг мөн үетэй харьцуулахад 32,8 хувиар өссөн.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын соёлыг төлөвшүүлэх хөтөлбөр”, “Эрүүл цагдаа хөтөлбөр”, “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын ахмад, дунд залуу үеийн залгамж холбоог хөгжүүлэх хөтөлбөр”, Цагдаагийн газрын хэмжээнд “Эерэг хандлагыг төлөвшүүлье” 45 хоногийн аян, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон талт арга хэмжээг алба хаагчид, иргэд олон нийтийн оролцоонд түшиглэн зохион байгуулсны үр дүнд алба хаагчдын ажиллах орчин нөхцөл сайжирсан, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчилсан, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлсэн зэрэг эерэг хандлагууд гарч байна.

“Эрүүл цагдаа” хөтөлбөрийн хүрээнд алба хаагчдын дунд хорт зуршлын талаар тандалт судалгаа явуулахад тамхи татдаг алба хаагч 29, хөдөлгөөний дутагдалтай, буруу хооллолтой 22 алба хаагч илэрсэн. Тамхи татдаг алба хаагчдын тоо өнгөрсөн онтой харьцуулахад 3 нэгжээр буюу 9 хувиар буурсан.

Алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд Зуунмод сум Манзушир өргөө хотхонд 30 айлын орон сууц, тэдний чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, бие бялдарыг чийрэгжүүлэх, сурах орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр “Бялдаржуулах танхим”, “Хөгжлийн өргөө”-г шинээр барьж, “Сургалтын танхим”-д засвар хийн бүрэн тохижуулж, цагдаагийн газрын конторын байр болон гадна талбайг засч тохижуулан орчин нөхцөлөө сайжруулаад байна.

Монгол улсад хууль сахиулах байгууллагын шинэчлэлтэй холбогдуулан Нээлттэй нийгэм форумаас явуулж байгаа төслийн хүрээнд Төв аймгийн ажил олгогч эздийн холбоо, Өмгөөлөгчдийн холбоо, Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн холбоо, Үйлдвэрчний эвлэлийн холбоодоос тус газрын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдал, иргэд, олон нийтэд тайлан тавьж байгаа байдал зэрэгт бэсрэг мониторинг хийж үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдал хуулийн дагуу, ил тод байдал хангалттай байна гэсэн дүгнэлт ирүүлсэн.

### **Дөрөв. Санал**

1. Монгол улсын Засгийн газрын 2017 оны “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 01 дүгээр албан даалгавар, Засгийн газрын 2018 оны “Төрийн алба хаагчийн сахилга хариуцлагыг сайжруулах тухай” 258 дугаар тогтоолыг хэрэгжүүлж, алба хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх, албанд хандах хандлагыг нэмэгдүүлэх, чадавхижуулах чиглэлээр сургалт, соён гэгээрүүлэх ажлыг алба хаагчдын оролцоонд тулгуурлан зохион байгуулах
2. Мал хулгайлах, хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр орон нутгийн онцлогт тохируулан төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж, хяналт шалгалтыг тогтмолжуулах
3. Үер ус, байгалийн гэнэтийн аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл, сурталчилгааны ажлыг иргэд олон нийтэд хүргэх, алба хаагчдын аюулгүй байдлыг хангах